

НИЙСЛЭЛИЙН АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ГАЗАР



2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2018.12.24

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН 3-9

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Монгол Улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт
Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хэмжээний хэрэгжилт

Улсын болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын хэрэгжилт

Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН 10-11

Улсын Их Хурал болон Байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Засгийн газрын тогтоолын хэрэгжилт, Засгийн Газрын хуралдааны тэмдэглэл

МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигийн хэрэгжилт

Ерөнхий сайдын захирамжийн хэрэгжилт

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт

Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, даргын зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт

Нийслэлийн Засаг даргаас зарласан зорилтот ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН 11- 48

Дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилт

Хүний нөөцийн чадавхижуулалт, нийгмийн баталгаа

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт

Архив, албан хэрэг хөтлөлт

Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа

Төсөв, санхүү, орлого бүрдүүлэлт

“Нийслэлийн хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан”-д гаргасан тайлан мэдээ

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ 49- 52

Үйл ажиллагааны ил тод байдал

Хүний нөөцийн ил тод байдал

ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД МЭДЭЭЛЭЛ 53 - 60

Холбогдох чиг үүргийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагуудтай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр хамтран ажилласан тухай

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу зохион байгуулсан үйл ажиллагааны талаар

Дотоод хяналт шинжилгээ үнэлгээний талаар

Байгууллагын эд хөрөнгийн ашиглалт хамгаалалтын талаар

Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газар нь тайлант хугацаанд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэлийн агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор батлагдсан “Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр”, Агаарын тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжийг мөрдүүлэх замаар агаарын бохирдлыг бууруулах нөхцлийг бүрдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа.


Бодлогын баримт бичгийн хэрэгжилт 2018 оны жилийн эцсийн байдлаар:

- Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн тус газарт хамаарал бүхий 1 зорилтын 15 заалтын хэрэгжилт 94%
- Монгол Улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн тус газарт хамаарал бүхий 1 зорилт, 1 арга хэмжээний хэрэгжилт 100%
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан 3 зорилт, 10 арга хэмжээний хэрэгжилт 89.1%
- Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд туссан 10 зорилт, 19 арга хэмжээний биелэлт 96.2% -тай байна.

Байгууллагын бодлогын зорилтуудын хэрэгжилтийн тайланг сар, улирал, хагас жилээр нэгтгэн гаргаж хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг Газрын даргын зөвлөлийн хурлаар улирал тутам хэлэлцүүлж хэвшсэн ба биелэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүдэд тухай бүр тайлагнаж ажиллав.

Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлын хэрэгжилт:

1. Засгийн газрын 324-р тогтоол, НЗД-ын А/980, А/1005 захирамжийн дагуу Нийслэлийн Агаарын чанарыг сайжруулах 1,2 дугаар бүсэд орших ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн анги танхим, эмнэлгийн хүүхдийн тасгийн өрөө, тасалгааг агаар цэвэршүүлэгчээр хангах ажлын хүрээнд 5270 агаар цэвэршүүлэгчийг нийлүүлсэн. Үүнд: Нийслэлийн ерөнхий боловсролын 139 сургуульд 3320, 238 цэцэрлэгт 982, эрүүл мэндийн төв, амаржих газруудад 968 агаар цэвэршүүлэгчийг тус тус олгосон.
2. Нийслэлийн Засаг даргын А/856 дугаар захирамжаар эрх шилжигдэн ирсэн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Цэцэрлэгийн дотоод орчны агаарын чанарыг сайжруулах агаар цэвэршүүлэгчээр хангах ажлын хүрээнд 175 агаар цэвэршүүлэгчийг хүлээн авч нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүлээлгэн өгсөн ба энэ нь шинээр ашиглалтанд орох цэцэрлэгүүдэд олгох юм.



Зураг 1. Цэцэрлэгийн дотоод орчны агаарын чанарыг сайжруулах зорилгоор 175 ширхэг агаар цэвэршүүлэгчийг НӨМХ-т хүлээлгэн өгсөн байдал

3. Агаар орчны хяналтын суурин харуулын хэмжилтийн тасралтгүй ажиллагааг хангах ажлын хүрээнд Дэлхийн банкны “Улаанбаатар-Цэвэр агаар төсөл”-ийн нэгжид 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 03/82 дугаар албан бичгээр 4 мэдээлэл цуглуулагч авах хүсэлт гарган, техникийн тодорхойлолтыг хүргүүлсэн. Техникийн тодорхойлолтын дагуу 2018 оны 02 дугаар сарын 26-нд WPLT-03 дугаар бүхий нээлттэй сонгон шалгаруулалт зарлан, гүйцэтгэгчээр “Эйм Ай Эс Эс” ХХК шалгарсан ба Франц улсын Enviroment SA компанийн eSAM брэндийн мэдээлэл цуглуулагчийг 2018 оны 8-р сарын 13-ны өдөр хүлээн авсан.
4. Нийслэлийн Засаг даргын 2018 оны “Утаагүй Улаанбаатар хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх агаарын бохирдлыг бууруулах төсөл, арга хэмжээг зохион байгуулах тухай А/430 дугаар захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийгдэх 7 төсөл арга хэмжээ батлагдсанаас нэг ажил бүрэн хэрэгжиж, бусад ажил сонгон шалгаруулалтын шатандаа байна. Үүнд:
 - Агаар орчны хяналтын суурин харуулд 2-оос доошгүй хий тохируулагч төхөөрөмж худалдан авах техникийн тодорхойлолт боловсруулан 2018 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 03/321 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Тус арга хэмжээг гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах ажлыг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдөр олон нийтэд нээлттэй зарлан, гүйцэтгэгч аж ахуйн нэгжээр “Интерсайнс” ХХК шалгарсан. 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдөр Интерсайнс ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж 2018 оны 10 дугаар сарын 19-нд хийн тохируулагч хийгч АРМС370 төрлийн 2 төхөөрөмжийг хүлээн авч суурилуулах ажил хийгдэж байна.
 - “Төвийн дулаан хангамжид холбогдох боломжгүй төрийн өмчийн 10-аас доошгүй барилгын дулааныг байгаль орчинд ээлтэй технологиор шийдвэрлэх” арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газрын даргын 2018 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/20 дугаар тушаалаар УБХЗАА, НХТЕТГ, НАББГ, “УБЦТС”-ТӨХК зэрэг байгууллагуудын төлөөлөл бүхий техникийн тодорхойлолт боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд нийслэлийн төвийн 6 дүүргийн 24 хорооны барилгын дулаан хангамжийг цахилгаан халаагуураар шийдэхэд эх үсвэрийн хүчдэл хүрэлцээтэй эсэх талаар мэдээлэл авах зорилгоор “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Техникийн бодлого зохицуулалтын хэлтэст 2018 оны 06 дугаар сарын 08-ний өдрийн 02/334 дугаарт албан бичгээр хүсэлт хүргүүлэн судалгаа мэдээлэл авч төвийн дулаан хангамжид холбогдох боломжгүй 10 барилгын дулаан хангамжийг цахилгаан халаагуураар шийдэхээр болсон. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт гүйцэтгэгчийг сонгон

шалгаруулах ажил хийгдсэн боловч ирүүлсэн материалууд шаардлага хангаагүй тул тендерийг хүчингүй болгож, дахин зарлаад байна.

- Зарим төвлөрсөн дулаан хангамжид холбох боломжтой барилгуудын халаалтын зуухыг буулгах ажлын санхүүжилтийг шийдвэрлэсэн. Тус арга хэмжээний хүрээнд эхний ээлжинд төвлөрсөн дулаан хангамжид холбох шаардлагатай 2 байгууламжийн техникийн нөхцөл, зураг төсвийг боловсруулан Нийслэлийн Засаг даргын Ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогчоор 2018 оны 05 дугаар сарын 28-ны өдөр батлуулан, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-т Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газрын 03/338 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Сонгон шалгаруулалтын ажлыг НХААГ-аас зохион байгуулж, захиалагчийн хяналтыг Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар тавьж ажиллаж байна.

Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрт заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын мэдээлэл

Хүснэгт 1.

№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Явцын мэдээлэл
Зорилт 2. Байгальд ээлтэй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх замаар бохирдлын эх үүсвэрийг багасгаж, түүхий нүүрсний хэрэглээг үе шаттайгаар хориглож, бохирдуулах бодисын хаягдлыг бууруулах			
Үйл ажиллагааны чиглэл 1. Хот суурин газрын “Агаарын чанарыг сайжруулах бүс”-ийг шинэчлэн тогтоож, халаалтын зориулалтаар шатааж хэрэглэхийг хориглох зүйлсийн жагсаалтыг гарган мөрдүүлэх			
2.1.1	Агаарын тухай хуулийн дагуу Агаарын чанарыг сайжруулах бүсийг тухай бүр шинэчлэн тогтоож, журмын хэрэгжилтийг хангах	Бүсийг шинэчлэн тогтоосон шийдвэр, бүсэд мөрдөх журам	Нийслэлээс шинэчлэн боловсруулсан Агаарын чанарыг сайжруулах 2018-2019 оны бүс мөн түүнд мөрдөх журамд БОАЖЯ саналаа тусган 2018 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 01/3858 дугаарт албан бичгээр манайд ирүүлсэн. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан 2018 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн хамтарсан А/226-А619 дугаарт тушаал, захирамжаар Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоож, түүнд мөрдөх журмыг шинэчлэн баталсан.
Үйл ажиллагааны чиглэл 2. Дулааны станц, дулааны цахилгаан станц бусад хэрэглээнд түүхий нүүрсийг үе шаттайгаар хориглох			
2.2.2	Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт дулааны станц, дулааны цахилгаан станцаас бусад хэрэглээнд түүхий нүүрс хэрэглэхийг үе шаттайгаар хориглох	Түүхий нүүрсийг халсан агаарын чанарыг сайжруулах 4-р бүс	Нийслэлээс шинэчлэн боловсруулсан Агаарын чанарыг сайжруулах 2018-2019 оны бүс мөн түүнд мөрдөх журмын төсөлд агаарын чанарыг сайжруулах 4-р бүсэд түүхий нүүрсний хэрэглээг бүрэн хориглосон.
Үйл ажиллагааны чиглэл 3. Гэр хорооллын айл өрхийг стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр хангах, сайжруулсан түлшний үйлдвэрийг дэмжин түүхий нүүрсний хэрэглээг оруулах			

3.3.1	Нийслэлийн гэр хорооллын айл өрх, аж ахуй нэгж, байгууллагыг стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр хангах, сайжруулсан түлш үйлдвэрлэх үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх	Сайжруулсан түлшний үйлдвэрүүдэд үзүүлэх	“Монгол шахмал түлш үйлдвэрлэгчдийн нэгдэл” –д үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэвийн явуулах зориулалтаар газар олгох хүсэлтийг 2018 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 01/298 тоотойр Нийслэлийн Газрын албанд хүргүүлэн тус нэгдэлд Хан-уул дүүргийн 10 хорооны нутаг дэвсгэрт сайжруулсан түлшний үйлдвэрлэл явуулах 10 га газрыг олгосон.
3.3.2	Сайжруулсан түлш нөөцлөх, түгээлт, борлуулалтын цэгүүдийг бий болгох	Боловсруулсан түлшний нөөцлөх цэг, борлуулалтын сүлжээ	Нийслэлийн Нутгийн Захиргааны байгууллагуудад 2018 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн 02-02/824 дугаарт албан бичгээр төвийн 6 дүүрэгт түлш нөөцлөх агуулах, мөн түлш борлуулдаг зах, айл өрхийн судалгааг гарган ирүүлэх тухай албан бичгийг хүргүүлэн, дүнг нэгтгэн, мэдээллийн санг үүсгэлээ.

Үйл ажиллагааны чиглэл 4. Гэр хорооллын 2 тарифт тоолууртай айл өрхийн шөнө хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний үнийг 50-100 хувь хөнгөлөх

2.4.1	Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхийн шөнийн цахилгаан эрчим хүчний хөнгөлөх	Шөнийн цахилгаан эрчим хүчийг хөнгөлөх	Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 199 дүгээр тогтоол, Эрчим хүчний зохицуулах хорооны 2017 оны 203, 204 дүгээр тогтоолын дагуу 2017 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлж эхэлснээс хойш 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл нийт 112,760 айл өрхөд 107.7 сая кВт.цаг цахилгааны 9.39 тэрбум төгрөгийн хөнгөлөлтийг олгосон байна.
2.4.2	Агаарын чанарыг сайжруулах бүсийн зорилтот бүлгийн айл өрхийг сайжруулсан зуух, түлш болон цахилгаан халаагуураар хангах дэмжлэг үзүүлэх	Дэмжлэгт хамруулж, зуух олгосон зорилтот бүлгийн айл өрх	“Монварт” ХХК-тай 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрөөс 2018 оны 04 дүгээр сарын 15-ны хүртэл “Агаарын чанарыг сайжруулах бүсэд амьдарч байгаа зорилтот бүлгийн иргэдийг дэвшилтэт технологи бүхий халаагуураар хангах” гэрээ байгуулсан. Гэрээний бараа нийлүүлэх хуваарийн дагуу 2018 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр 155 цахилгаан халаагуурыг нийлүүлэн хүлээлгэн өгсөн. Гэрээнд хяналт тавих зорилгоор Нийслэлийн Засаг даргын ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогчоор батлуулсан удирдамжийн дагуу 2018 оны 03 дугаар сарын 09 ноос – 19-ны хооронд цахилгаан халаагуур авсан айл өрхөөр

			<p>орж заваар зөвлөгөө, албан шаардлага өгч ажилласан.</p> <p>Нийслэлийн Халамж үйлчилгээний газраас ирүүлсэн 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 2/429 дугаар бүхий албан бичгийн дагуу “Монварт ХХК-нь 25 өрхөд цахилгаан халаагуурыг бүрэн нийлүүлж хүлээлгэн өгсөн.</p>
		Зорилтот бүлгийн айл өрхөд нийлүүлсэн боловсруулсан түлшээр хангах	<p>Нийгмийн халам, үйлчилгээ зайлшгүй шаардлагатай гэр хорооллын айл өрхийн судалгааг дүүрэг, хороогоор гаргах зорилгоор Нийслэлийн Нийгмийн халамжийн газарт 2018 оны 01 дүгээр сарын 31-ний 02/59 дугаарт албан бичгээр хүргүүлэн, дүнг нэгтгэн мэдээллийн сан бүрдүүлсэн. Нийслэлийн хэмжээнд 62700 зорилтот бүлгийн иргэн байна.</p>
<p>Үйл ажиллагааны чиглэл 15. Агаар, орчны бохирдол, хүлэмжийн хийг бууруулах инновацийн судалгаа, технологийн хөгжлийг дэмжин санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, олон улсын сангуудаас санхүүгийн дэмжлэг авахад дэмжлэг үзүүлэх</p>			
2.15.2	Төвлөрсөн дулаан хангамжийн нэгдсэн системд холбоогдоогүй алслагдсан төрийн байгууллагын дулаан хангамжийг сэргээгдэх эрчим хүч болон бусад үр ашигтай технологи ашиглан шийдэх	53 хорооны барилгын дулааны хангамжийг шийдвэрлэсэн төсөл	<p>Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газрын даргын 2018 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/20 дугаартай тушаалаар техникийн тодорхойлолт боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэгт УБХЗАА, НХТЕТГ, НАББГ, “УБЦТС”-ТӨХК зэрэг байгууллагуудын төлөөлөл орсон. Нийслэлийн төвийн 6 дүүргийн 24 хорооны барилгын дулаан хангамжийг цахилгаан халаагуураар шийдэхэд эх үүсвэрийн хүчдэл хүрэлцээтэй эсэх талаар мэдээлэл авах зорилгоор “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Техникийн бодлого зохицуулалтын хэлтэст 2018 оны 06 дугаар сарын 08-ний өдрийн 02/334 дугаарт албан бичгээр хүсэлт хүргүүлсэн. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажил хийгдсэн боловч ирүүлсэн материалууд шаардлага хангаагүй тул тендерийг хүчингүй болгож, дахин зарлаад байна.</p>
<p>Үйл ажиллагааны чиглэл 16. Агаар, орчны бохирдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт техник, технологийг олон нийтэд таниулах “Байгаль орчинд ээлтэй техник, технологийн үзэсгэлэнгийн төв”-ийг байгуулах</p>			
2.16.1	Агаар, орчны бохирдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт техник, технологийг олон нийтэд таниулах “Байгаль орчинд ээлтэй техник, технологийн үзэсгэлэнгийн төв” /Show room/-ыг	Байгаль орчинд ээлтэй техник, технологийн үзэсгэлэнгийн төв	<p>Чингэлтэй дүүргийн 12-р хорооны нутаг дэвсгэр Наран туул худалдааны төв -2-ын хажууд “Байгаль орчинд ээлтэй техник, технологийн үзэсгэлэнгийн төв үзэсгэлэнгийн төв байгуулагдсан. Мөн Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэгт мэдээллийн төв байгуулах ажлын техникийн тодорхойлолт боловсруулан 2018 оны 10 дугаар сарын 31-ний</p>

	нийслэлийн 3-аас доошгүй байршилд байгуулах		өдрийн 02/553 дугаарт албан бичгээр Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн бөгөөд нээлттэй сонгон шалгаруулалтыг 2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр зарласан. Сонгон шалгаруулалтын ажил явагдаж байна.
Зорилт 3. Автотээврийн хэрэгслээс ялгарах бохирдуулагч бодисын хэмжээг бууруулах цогц арга хэмжээ авах			
Үйл ажиллагааны чиглэл 3. Тээврийн хэрэгслийг хийн түлш, цахилгаан эх үүсвэрт шилжүүлэх, байгаль орчинд сөрөг нөлөө багатай техник, технологи, тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх чиглэлээр судалгаа хийж турших, нийтийн тээврийн хэрэгслийг хийн түлшинд үе шаттайгаар шилжүүлэх			
3.3.3	Нийслэлийн нийтийн тээврийн дизель автобусанд утааны тортог шүүгч DPF, түүнийг цэвэрлэх тоног төхөөрөмжийг суурилуулах, байнгын үйлчилгээ хийх	Дизель автобусанд суурилуулсан DPF шүүлтүүрийг цэвэрлэх тоног төхөөрөмж, тогтмол үйлчилгээ	Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 128 дугаар тушаалаар автотээврийн хэрэгслээс ялгарах утааг багасгах талаар санал, холбогдох шийдвэрийн төсөл, төлөвлөгөө боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсэг Япон Улсын олон улсын хамтын ажиллагааны "ЖАЙКА" байгууллагатай хамтран нийтийн зорчигч тээврийн 25 автобусанд суурилуулсан. Нийтийн тээврийн автобусанд DPF суурилуулах ажлын хүрээнд нэг автобусыг 2018 оны 6-р сарын 15-26-ны хооронд засварт ороогүй, орсон болон DPF суурилуулсан, суурилуулаагүй эсэхээр тус тусад нь замын хөдөлгөөнд оролцуулж (NOx, PM)-ын хэмжилт хийсэн. Хаягдал утааны хэмжээ болон шатахуун зарцуулалтыг засварт орсон, ороогүй, DPF суурилуулсан, суурилуулаагүй байдлуудаар нь харьцуулахад DPF суурилуулсан хэмжилтээр NOx, PM-ын буурсан үр дүнтэй байсан. DPF-гүй засварт орсон (тос сольж, агаар шүүгчийг сольсон) үеийг DPF-гүй засвар үйлчилгээ хийгдээгүй үетэй харьцуулан үзэхэд NOx нь 1.43гр/км/тонн-оор буюу 3 хувиар буурсан, PM нь 0.080гр/км/тонн 11 хувиар, шатахуун зарцуулалт 0.37л/км 9 хувиар буурсан. Энэ нь засвар үйлчилгээг тогтмол хийх нь автомашинаас ялгарах бохирдлыг бууруулахад үр дүнтэй нь харагдаж байна. DPF-тэй засвар хийсэн үеийг DPF-гүй засвар хийсэн хэмжилттэй харьцуулахад NOx 1.36гр/км/тонн 5 хувиар, PM нь 0.008гр/км/тонн 90 хувиар тус тус буурсан, шатахуун зарцуулалт 0.35л/км 4 хувиар буурсан байна.
3.3.4	Нийтийн зорчигч тээврийн автобусанд "Эко жолоодлого"-ын хяналтын	1. "Эко жолоодлого"-ын хяналтын төхөөрөмжийг суурилуулсан 10 автобус	1. 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдөр Зорчигч Тээврийн нэгтгэлийн 7 -н

	төхөөрөмжийг нэвтрүүлэх, таниулах суурилуулж, сурталчлан	2. Туршилт, ажлын тайлан судалгааны 3. Сургалт нэвтрүүлэх, таниулах сурталчилгаа сурталчлан	автобусанд “Эко жолоодлого”-ын камер суурилуулсан. 2. “Эко жолоодлого”-ын хяналтын төхөөрөмжийг суурилуулж, нэвтрүүлэх, сурталчлан таниулах, тайлан боловсруулах ажил хүрээнд 2 удаа мэдээлэл авсан, хангалттай мэдээлэл цуглуулаагүй тул тус ажлын үр дүнг тооцох ажил тасарсан. “Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний чадавхыг бэхжүүлэх төсөл” -ийн 3 дугаар үе шатанд “Эко жолоодлого” ажлыг хэрэгжүүлэхээр болсон. 3. Эко жолоодлогыг сурталчлан таниулах зорилгоор сурталчилгааны хэвлэмэл хуудсыг гарган 2018 оны 6-р сараас эхлэн иргэд олон нийтэд түгээн, танилцуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.
Зорилт 5. Орчны бохирдлыг бууруулахад иргэд, олон нийтийг оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, эрүүл амьдрах зөв дадлыг төлөвшүүлэх, орчны чанарын хяналт-шинжилгээний чадавхыг бэхжүүлэн судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлэх			
Үйл ажиллагааны чиглэл 10. Агаар, орчныг бохирдуулж байгаа эх үүсвэр, хаягдлын тооллого явуулж, бүртгэл, мэдээллийн санг шинэчлэн бүрдүүлэх			
5.10.1	Агаарын бохирдлын эх үүсвэрийн бүртгэл, тооллого явуулж, бүртгэл мэдээллийн цахим санг бүрдүүлэх	Агаарын бохирдлын эх үүсвэр, өрхийн бүртгэл, мэдээллийн сан	Агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэлийг 2018 онд 2 удаа зохион байгуулсан. НЗД-ын 2018 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/398 дугаар захирамжийн дагуу бага, дунд оврын халаалтын зуухны байгууламжийн дахин бүртгэл тооллогын ажлыг 2018 оны 06 дугаар сард зохион байгуулсан. Тус тооллогын ажлаар нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд 15-100кВт хүчин чадалтай 2397 зуух бүртгэгдсэн. БОНХС-ын 2014 оны А/181 дүгээр тушаалаар баталсан "Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах журам"-ын дагуу агаарын бохирдлын эх үүсвэрийн бүртгэл тооллогын ажлыг 10-12 дугаар сард зохион байгуулсан. Тус тооллогын ажлаар нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд 3-15кВт хүртэлх хүчин чадалтай 171619 ахуйн хэрэглээний зуух, 15-100кВт хүчин чадалтай нам даралтын 2397 халаалтын зуух, 100кВт-аас дээш хүчин чадалтай 200 байгууламжийн 384 уурын болон усан халаалтын зуух бүртгэгдлээ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

а).Тус газрын үйл ажиллагааны чиг үүрэгтэй хамаарал бүхий 8 тогтоол, 21 захирамж, үүрэг даалгаврын 62 заалтыг хяналтанд авч хэрэгжилтийг **Нийслэлийн хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан** monitoring.ub.gov.mn –д болон албан бичиг, цахим хаягаар тайлагнаж ажиллав.

1. Улсын Их Хурлын 1 тогтоолын 1 заалтын хэрэгжилт 100%
2. Улсын Их Хурлын Байнгын хорооны 1 тогтоолын 8 заалтын хэрэгжилт 92,5%
3. МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигийн 2 заалтын хэрэгжилт 100%
4. МУ-ын Засгийн газрын 5 тогтоолын 25 заалтын хэрэгжилт 93%
5. Засгийн газрын 6 хуралдааны тэмдэглэлийн 10 заалтын хэрэгжилт 70%
6. Засгийн газрын 1 албан даалгаврын 11 заалтын хэрэгжилт 100%
7. МУ-ын Ерөнхий сайдын 1 захирамжийн 1 заалтын хэрэгжилт 100%
8. НИТХ-ын 4 тогтоолын 6 заалтын хэрэгжилт 95%
9. Нийслэлийн Засаг даргын 4 захирамжийн 4 заалтын хэрэгжилт 100%
10. Нийслэлийн Удирдлагуудаас өгсөн 8 үүрэг даалгаврын 10 заалтын хэрэгжилт 93%

б) Нийслэлийн Засаг даргаас тухайн жилд хэрэгжүүлэхээр зарласан зорилтот ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Нийслэлийн удирдах ажилтны 22 удаагийн шуурхай зөвлөгөөний 52 үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган, биелэлтийг НЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ulaanbaatar.mn сайтад байршуулан ажиллалаа. Шуурхай зөвлөгөөний үүрэг даалгаврыг газрын удирдлага, хэлтсийн дарга нарт танилцуулан, 14 хоногийн ажлын биелэлт, тайлан болон 14 хоног тутмын төлөвлөгөөг тогтмол хугацаанд гаргуулж нэгтгэн НЗДТГ-ын ХШҮХ-ийн monitoring@ulaanbaatar.mn цахим хаягаар цаг хугацаанд нь хүргүүлж тайлагнан ажиллаж байна.

БОАЖ-ын сайд болон НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын хооронд байгуулсан байгаль орчин, аялал жуулчлалын салбарт 2018 онд хамтран ажиллах гэрээнд заагдсан тус газартай хамаарал бүхий 3 заалтын биелэлтийг гарган ажиллалаа. Гэрээнд заагдсан 3 заалтын биелэлт 100% -тай байна.

Нийслэлийн Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/918 дугаар захирамжаар батлагдсан хуваарь, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтнуудын хороодод ажиллах удирдамжийн дагуу байгууллагын удирдах албан тушаалтнууд СХД-ийн 27,28,29,30, ХУД-ын 8-р хороодуудад 14 хоног тутам Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн бие төлөөлөл болон, хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан болоод Нийслэлийн удирдлагын зүгээс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ цаашид авч хэрэгжүүлэх бодлого, шийдвэрийг танилцуулан, иргэдээс гарч байгаа санал, хүсэлт, гомдлыг тухай бүрд нь тэмдэглэж, холбогдох байгууллагад уламжлан ажилласан.



Зураг 2. НАББГ-ын удирдлагууд СХД, ХУД-ийн хороодод ажиллав.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ


Агаарын тухай хууль, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хүрээнд:

1. Улаанбаатар хотын агаарын чанарыг 11 суурин харуулаар 6 төрлийн бохирдуулагч бодисыг 24 цагийн турш тасралтгүй хэмжиж, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын А-327 дугаарт тушаалаар батлагдсан “Агаарын чанарыг агаарын чанарын индексээр үнэлэх, мэдээлэх ерөнхий журам”-аар буюу агаарт агуулагдах хорт бодисын хэмжээг агаарын чанарын хүлцэх хэм хэмжээнд (MNS 4585:2016) харьцуулан гарах тоон утгыг хувьчлан тодорхойлж эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийг өнгөөр илэрхийлэн олон нийтэд мэдээллэн ажиллаж байна. Агаарын чанарыг олон нийтэд ойлгомжтой, үндэслэлтэй мэдээллэхэд агаарын чанарын индекс бодох аргачлалыг өөрчлөх шаардлагатай байгаатай уялдуулан Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/327 дугаарт тушаалаар батлагдсан “Агаарын чанарыг агаарын чанарын индексээр үнэлэх, мэдээлэх ерөнхий журам”-ыг шинэчлэх асуудлыг шийдвэрлүүлэх үндэслэл, судалгааг боловсруулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад 2018 оны 03 дугаар сарын 06-ны өдөр 02-02/797 дугаарт албан бичгээр хүргүүлсэн. Энэхүү судалгаанд үндэслэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайд 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/387 дугаар тушаалаар “Агаарын чанарын индексээр агаарын чанарыг үнэлэх, мэдээллэх журам”-ыг шинэчлэн баталсан.
2. “Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах журам батлах тухай” Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн А/181 дугаар тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах саналаа 2018 оны 01 дугаар сарын 23 өдрийн 02-02/254 дугаар албан бичгээр Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн. Манай байгууллагаас гаргасан саналд үндэслэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайд 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/479 дугаар тушаалаар “Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл хийх журам”-ыг шинэчлэн баталсан.
3. Агаарын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь заалт, БОНХС-ын 2014 оны А/181 дүгээр тушаалаар батлагдсан “Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах журам”-ын хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах ажлын хүрээнд агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэлийг 2018 онд 2 удаа зохион байгуулсан. Үүнд:

- НЗД-ын 2018 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/398 дугаар захирамжийн дагуу бага, дунд оврын халаалтын зуухны байгууламжийн дахин бүртгэл тооллогын ажлыг 2018 оны 6 дугаар сард зохион байгуулсан. Тус тооллогын ажлаар нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд 15-100кВт хүчин чадалтай 2397 зуух бүртгэгдсэн.

- Агаарын бохирдлын эх үүсвэрийн бүртгэл тооллогыг 10-12 дугаар саруудад зохион байгуулсан. Тус тооллогоор нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд 3-15кВт хүртэлх хүчин чадалтай 171619 ахуйн хэрэглээний зуух, 15-100кВт хүчин чадалтай нам даралтын 2397 халаалтын зуух, 100кВт-аас дээш хүчин чадалтай 200 байгууламжийн 384 уурын болон усан халаалтын зуух бүртгэгдлээ.

4. Агаарын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дахь хэсэгт "Төрийн захиргааны төв байгууллага нь нутгийн захиргааны байгууллагатай хамтран агаарын бохирдлыг бууруулах зорилгоор агаарын чанарыг сайжруулах бүсийг тогтоож, тухайн бүсэд мөрдөх журмыг батална" гэж заасны дагуу Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн, мөн тухайн бүсэд мөрдөх журмын төслийг боловсруулан Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг даргын 2018 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн хамтарсан А/226-А619 тушаал, захирамжаар бүсчлэл, журмыг шинэчлэн батлуулсан.



Зураг 3. Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулах бүсүүд.

5. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд "Шингэрүүлсэн хийн аж ахуй эрхлэгчдийн холбоо" ТББ-тай хамтран Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны Тээврийн хэрэгслийн улсын дугаарын хязгаарлалтын цаг, бүсчлэлийг шинэчлэн тогтоох тухай 225 дугаарт тогтоолд үндэслэн нийслэлийн Засаг даргын 2017 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн А/595 дугаарт захирамжид "хийн түлшээр явдаг тээврийн хэрэгсэл"-ийг хөдөлгөөнд дугаарын хязгаарлалтгүй оролцуулах өөрчлөлтийн төслийг боловсруулж, шийдвэрлүүлэхээр нийслэлийн Тээврийн газарт 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 03/380 дугаарт албан бичгээр уламжлаад байна.
6. Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/163 дугаар захирамж "Утаагүй Улаанбаатар хөтөлбөр"-ийн хүрээнд "Агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөө боловсруулах" зөвлөх үйлчилгээний ажил тусгагдаж "Экотайкүүн" ХХК-тай гэрээ

байгуулан ажилласан. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Байгаль орчин, ногоон хөгжлийн хорооны хурлаар хэлэлцүүлэн хурлаас гарсан шийдвэрийн дагуу хороотой хамтран “Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөө”-ний төслийн санал солилцох, зөвлөлдөх уулзалтыг 2018 оны 06 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсан. Уулзалтад НИТХ-ын төлөөлөгчид болон холбогдох 50 гаруй байгууллага оролцсон. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн хурлаар агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөөний нэрийг “Нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөө” гэж томъёолон, 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XVII хуралдаанаар баталсан. Мастер төлөвлөгөөний 1-р үе шат нь 5 зорилт, 29 үйл ажиллагааны үндсэн чиглэл бүхий 80 үйл ажиллагааг 2018-2019 онд, 2-р үе шат нь 5 зорилт, 29 үйл ажиллагааны үндсэн чиглэл бүхий 72 үйл ажиллагааг 2020-2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.



Зураг 4. НИТХ-ын XVII хуралдаанаар Нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөөг батлуулсан.

Агаарын чанарын улсын хяналт-шинжилгээний сүлжээний нэгжийн тасралтгүй үйл ажиллагааг хангах, хүрээлэн буй орчинд мониторинг хийх зорилтын хүрээнд:

Толгойт, Баянхошуу, Нисэх, Амгалан, МҮОНРТ-ийн суурин харуулын төхөөрөмжүүдийн насжилт дууссан сэлбэг шүүлтүүрүүдийг солих, хийн тохируулгыг хуваарьт хугацаанд хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

2018 оны 12-р сарын 21-ны байдлаар суурин харуулуудын хэмжилтийн хүчинтэй баталгаат өгөгдөл 6000 цагаас дээш байх бөгөөд 8496 цагийн хэмжилтийн өгөгдөл цуглуулах ёстой. Баталгаат өгөгдлийг 2018 оны 12-р сарын 21-ны байдлаар суурин харуул тус бүрээр үзүүлвэл:

Толгойт - 7872 цаг – 92.%
Телевиз - 8425 цаг – 98.%
Амгалан - 8438 цаг – 99%
Нисэх - 8442 цаг – 99%
Баянхошуу - 8428 цаг – 99% байна.

Орчны 5 суурин харуулын мэдээг 7 хоног, сар тутам баталгаажуулж гэрээнд заасан хугацаанд ЦУОШГ-т хүргүүлсэн.

Суурин харуулуудын төхөөрөмжүүдийн ажилласан цагаар үзүүлэв:

Хүснэгт 2. Улаанбаатар хотын агаарын чанарын хяналтын суурин харуулуудын төхөөрөмжүүдийн ажилласан цаг

12/21/2018										
Хэмжилтийн төрлүүд	Амгалан		Нисэх		Толгойт		Телевиз		Баянхошуу	
	Хэмжих цаг	Хувь	Хэмжих цаг	Хувь	Хэмжих цаг	Хувь	Хэмжих цаг	Хувь	Хэмжих цаг	Хувь
	8496	хувь	8496	хувь	8496	хувь	8496	хувь	8496	хувь
	Хэмжсэн цаг		Хэмжсэн цаг		Хэмжсэн цаг		Хэмжсэн цаг		Хэмжсэн цаг	
NO2	8413	99%	8383	98%	6339	74%	8372	98%		
CO	5790	68%	4776	57%	7497	88%	5933	69%		
O3	8195	96%	8413	99%	4978	58%	2590	30%		
SO2	8115	95%	6776	79%	2970	34%	1862	21%	8199	96%
PM10	8416	99%	8416	99%	7444	87%	8127	95%	8011	94%
PM2.5	8416	99%	8416	99%	7444	87%	8127	95%	8124	96%
Ажилласан хувь		93%		89%		72%		68%		95%
Нийт	83,4%									

Эрчим хүчний хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх, гэр хорооллын айл өрхүүдийн цахилгааны үнийн хөнгөлөлтөнд хамруулах зорилтын хүрээнд:

Улаанбаатар хотод 2017 оны байдлаар 365397 цахилгаан эрчим хүч хэрэглэгч байгаагийн 152091 нь гэр хорооллын хэрэглэгч байна. Гэр хорооллын цахилгаан эрчим хүч хэрэглэгчийн 130580 буюу 85 хувь нь 2 тарифт тоолууртай. (2 тарифт тоолуургүй өрхийн тоо – 21028)

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 199 дүгээр тогтоол, Эрчим хүчний зохицуулах хорооны 2017 оны 203, 204 дүгээр тогтоолын дагуу 2017 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлж эхэлснээс хойш 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл нийт 112,760 айл өрхөд 107.7 сая кВт.цаг цахилгааны 9.39 тэрбум төгрөгийн хөнгөлөлтийг олгосон байна. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 199 дүгээр тогтоолоор батлагдсан "Гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журам"-ыг үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд оройн 21.00 цагаас өглөөний 06.00 цагийн хооронд гэр хорооллын хэрэглэгчдийн хэрэглэсэн цахилгааны төлбөрийг тэглэх шийдвэр гарсан.

Нийслэлийн гэр хорооллын айл өрхийн түүхий нүүрсний хэрэглээг бууруулах, сэргээгдэх эрчим хүч, цэвэр түлшний хэрэглээг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

1. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 18/01 тогтоолоор "Боловсруулсан түлш үйлдвэрлэж байгаа аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцаж, суурилагдсан болон боломжит хүчин чадлын тооцоог гаргаж, цаашид хамтран ажиллах боломж, шийдвэрлэх асуудлыг судлан танилцуулах" үүрэг бүхий Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны

нарийн бичгийн даргаар удирдуулан Монгол Улсын Ерөнхий Сайдын зөвлөх, Нийслэл болон Эрчим Хүчний Яамны холбогдох хэлтэс, газрын дарга, мэргэжилтнүүд болон шахмал түлш үйлдвэрлэгч компаниудын захирлуудын төлөөлөл бүхий нийт 16 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг томилон ажиллуулсан. Энэхүү ажлын хүрээнд Дархан уул, Дорноговь, Говьсүмбэр, Төв аймаг болон нийслэлд үйл ажиллагаагаа явуулж байгаа болон явуулах бололцоотой сайжруулсан түлшний 8 үйлдвэр, Эрдэнэс Таван толгой ТӨХК, “Энержи Ресурс” ХХК-ний 2 уурхайтай газар дээр нь очиж уулзан дараах асуудлыг шийдвэрлэсэн. Үүнд:

- “Энержи Ресурс” ХХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэрт угааж баяжуулсан эрчим хүчний нүүрс 2 гаруй сая тонн нүүрс байна. Тус аж ахуйн нэгж агаарын бохирдлыг бууруулах нийгэмд хүлээх хариуцлагын хүрээнд сайжруулсан түлш үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдэд угааж баяжуулсан нүүрсийг үнэ төлбөргүй олгох болсон.
- Нийслэлийн гэр хорооллын өрхийн хэрэгцээнд нийлүүлэх сайжруулсан шахмал түлшний чанар, стандартыг нэг түвшинд гаргах зорилгоор дээр дурьдсан угааж баяжуулсан нүүрсээр сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэгч 11 аж ахуйн нэгж сайн дурын үндсэн дээр нэгдсэн “Монгол шахмал түлш нэгдэл”-ийг шинээр байгуулах нөхцлийг бүрдүүллээ. Тус нэгдлийн суурилагдсан хүчин чадал 600 мянган тонн, бодит үйлдвэрлэлийн хүчин чадал нь 300 мянган тонн байна.



Зураг 5. Эрдэнэс Таван толгой ТӨХК-ий уурхайтай танилцан сайжруулсан түлшний үйлдвэрүүдэд баяжуулсан нүүрс нийлүүлэх боломжийн талаар санал солилцов.

Сайжруулсан түлш үйлдвэрлэн гэр хорооллын өрхийн хэрэгцээнд нийлүүлэх зорилгоор түлш үйлдвэрлэдэг 11 компани нэгдэж “Монгол шахмал түлш үйлдвэрлэгчдийн нэгдэл” ХХК-ийг байгуулсан. Тус нэгдэлийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор сайжруулсан түлшний үйлдвэр байгуулах, агуулах барихад зориулан газар олгох хүсэлтийг 2018 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 01/298 тоотойр Нийслэлийн Газрын албанд хүргүүлсэн. Улмаар тус нэгдэлд Хан-уул дүүргийн 10 хорооны нутаг дэвсгэрт сайжруулсан түлшний үйлдвэрлэл явуулах 10 га газрыг олгосон. Сайжруулсан түлшний үйлдвэрлэлийг дэмжих, түгээлт борлуулалтын сүлжээг байгуулах ажлын хүрээнд 9 газрын захирамж гарсан. Агаарын чанарыг сайжруулах бүсэд боловсруулсан түлшийг нөөцлөх, түгээх бэлтгэл ажлыг хангахаар Сонгино-хайрхан, Хан-уул, Баянзүрх дүүрэгт тус бүр агуулах барихаар техникийн тодорхойлолт, ажлын даалгавар боловсруулан Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 02/598 дугаар бүхий албан бичгээр сонгон шалгаруулалт зарлах хүсэлтийг хүргүүлсэн.



Зураг 6. Сайжруулсан түлшний үйлдвэр байгуулах, агуулах барих газрын байршилтай танилцаж байгаа нь.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор батлагдсан “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний” хөтөлбөрт “Байгаль орчинд ээлтэй техник, технологийн үзэсгэлэнгийн төв” /Show room/ нийслэлд 3-аас доошгүй байршилд байгуулахаар тусгагдсан. Энэ ажлын хүрээнд Чингэлтэй дүүргийн 12 дугаар хорооны хуучин барилгыг засварлан “Агаарын бохирдлыг бууруулах нэгдсэн мэдээллийн төв” болгон ашиглах талаар Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулалтын арга хэмжээ авч Чингэлтэй дүүргийн 12-р хорооны нутаг дэвсгэр /Наран туул худалдааны төв-2-ийн хажууд/-т “Мэдээлэл инновацийн төв”-ийг байгуулан, үйл ажиллагааг эхлүүлээд байна.

Мөн Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэгт мэдээллийн төв байгуулах ажлын техникийн тодорхойлолтыг боловсруулан 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 02/553 дугаарт албан бичгээр Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. НХААГ-аас нээлттэй сонгон шалгаруулалтыг 2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр зарлаж, сонгон шалгаруулалтын ажил явагдаж байна.



Зураг 7. Чингэлтэй дүүргийн 12-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Мэдээлэл инновацийн төвийн байр

2. Эрчим хүчний яамны Түлшний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Азийн хөгжлийн банктай хамтран түлш үйлдвэрлэж байгаа аж ахуй нэгжүүд болоод эрдэмтэн судлаачдын дунд сайжруулсан түлшний чанарын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлууд сэдэвт зөвлөлдөх уулзалтыг 2018 оны 06 дугаар сарын 08-ны өдөр зохион байгууллаа. Энэхүү зөвлөлдөх уулзалтаар түлшний шаталтаас ялгарах агаар бохирдуулагч бодис түүнийг тодорхойлох аргачлал стандартыг боловсруулах нь түүхий нүүрсний хэрэглээг хориглосон тухай Засгийн газрын 62

дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах улмаар агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай байгаа талаар харилцан зөвлөлдөж, санал солилцож, нэгдсэн саналд хүрээд байна.



Зураг 8. Эрчим хүчний яам, Азийн хөгжлийн банкттай хамтарсан сайжруулсан түлшний чанарын талаарх зөвлөлдөх уулзалт

3. Монгол орны нөхцөлд тохирсон байгаль орчинд ээлтэй техник, технологи, инновацийн шинэ санаа, шийдлийг нэвтрүүлэх, түгээн дэлгэрүүлэх, бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчид, олон нийтэд сурталчлан таниулах, шинийг санаачлагч, гарааны бизнес (Start-Up) эрхлэгчдийг хөрөнгө оруулагч, банк санхүүгийн байгууллага оролцогч талуудын хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх сэдэвт үзэсгэлэнд 2018 оны 05 дугаар сарын 28-29-ний өдрүүдэд оролцов. Агаарын бохирдлын талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, байгальд ээлтэй технологи, эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээ, сэргээгдэх эрчим хүч, сайжруулсан түлш, бохир усыг цэвэрлэх, эргүүлэн ашиглах, дахин боловсруулах, усны хэмнэлттэй техник технологи нэвтрүүлэх, биотехнологи, нано технологийг үйлдвэрлэл, хэрэглээнд нэвтрүүлэх, аюултай, хортой материалын хэрэглээнээс зайлсхийх, агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах, түүнийг хэмжих, хяналт тавих, ногоон зээлийн /Хас банк, Ариг банк, Ногоон санхүүгийн корпорац/ талаар холбогдох байгууллагууд мэдээлэл өгч ажилласан.



4. Нийслэлийн Засаг даргын “Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай” 2018 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А/430 дугаар захирамжаар “Төвийн дулаан хангамжид холбогдох боломжгүй төрийн өмчийн 10-аас доошгүй барилгын дулааныг байгаль орчинд ээлтэй технологиор шийдвэрлэх” арга хэмжээг баталсан.

Захирамжийн хүрээнд Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газрын даргын 2018 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/20 дугаар тушаалаар УБХЗАА, НХТЕТГ, НАББГ, “УБЦТС”-ТӨХК зэрэг байгууллагуудын төлөөлөл бүхий техникийн тодорхойлолт боловсруулах ажлын хэсэг байгуулан ажилласан. Тус арга хэмжээний хүрээнд нийслэлийн төвийн 6 дүүргийн 24 хорооны барилгын дулаан хангамжийг цахилгаан халаагуураар шийдэхэд эх үүсвэрийн хүчдэл хүрэлцээтэй эсэх талаар мэдээлэл авах зорилгоор “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Техникийн бодлого зохицуулалтын хэлтэст 2018 оны 06 дугаар сарын 08-ний өдрийн 02/334 дугаар албан бичгээр хүсэлт хүргүүлэн судалгаа мэдээлэл авч төвийн дулаан хангамжид холбогдох боломжгүй 10 барилгын дулаан хангамжийг цахилгаан халаагуураар шийдэхээр болсон. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил хийгдсэн боловч ирүүлсэн материалууд шаардлага хангаагүй тул тендерийг хүчингүй болгож, дахин зарлаад байна.

5. Зорилтот бүлгийн айл өрхөд байгаль, орчинд ээлтэй технологийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллалаа. Тус ажлын хүрээнд “Монватт” ХХК-тай 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрөөс 2018 оны 04 дүгээр сарын 15-ны хүртэл “Агаарын чанарыг сайжруулах бүсэд амьдарч байгаа зорилтот бүлгийн иргэдийг дэвшилтэт технологи бүхий халаагуураар хангах” гэрээ байгуулсан. Гэрээний бараа нийлүүлэх хуваарийн дагуу 2018 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр 155 цахилгаан халаагуурыг нийлүүлэн хүлээлгэн өгсөн. Гэрээнд хяналт тавих зорилгоор Нийслэлийн Засаг даргын ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогчоор батлуулсан удирдамжийн дагуу 2018 оны 03 дугаар сарын 09 ноос – 19-ны хооронд цахилгаан халаагуур авсан айл өрхөөр орж заваар зөвлөгөө, албан шаардлага өгч ажилласан. Нийслэлийн Халамж үйлчилгээний газраас ирүүлсэн 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 2/429 дугаар албан бичгийн дагуу “Монватт ХХК-нь 25 өрхөд цахилгаан халаагуурыг бүрэн нийлүүлж хүлээлгэн өгсөн.

“Агаарын чанарыг сайжруулах бүсийн зорилтот бүлгийн айл өрхүүдийг сайжруулсан түлшээр хангах ажлын хүрээнд:

- Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн зорилтот бүлгийн өрхүүдийг сайжруулсан түлшээр хангах ажлын хүрээнд амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой иргэдийн судалгааг хийсэн ба нэг хүнд сард ногдох хүн амын амьжиргааны доод түвшинг жил бүр шинэчлэн тогтоож байна. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд амьдарч байгаа амьжиргааны түвшингээс доогуур орлоготой гэр хорооллын айл өрхийн судалгааг дүүрэг, хороогоор гаргах зорилгоор Нийгмийн Халамжийн газарт 2018 оны 01 дүгээр сарын 31-ний 02/59 дугаарт албан бичгээр хүргүүлэн, дүнг нэгтгэн мэдээллийн сан бүрдүүлсэн. Нийслэлийн хэмжээнд 62700 зорилтот бүлгийн иргэн байна.

Хүснэгт 3. Нийслэлийн Агаарын чанарыг сайжруулах бүсэд амьдарч байгаа зорилтот бүлгийн иргэдийн судалгааны дүн

№	Дүүрэг	Амьжиргааны түвшингээс доогуур орлогтой өрхийн тоо
1	Багануур	1604
2	Багахангай	197

3	Налайх	2608
4	Баянгол	4142
5	Баянзүрх	14847
6	Сонгинохайрхан	19677
7	Сүхбаатар	4684
8	Хан-Уул	5238
9	Чингэлтэй	9703
	Нийт дүн	62,700

Сайжруулсан түлшний одоогийн үйлдвэрлэлийн боломжид түлгуурлан сайжруулсан түлшээр хангах 4 хувилбарыг гаргасан: Үүнд

Хувилбар 1: СХД-ийн 7,8,9,11,24,25,26,28 нийт 8 хорооны 26,6 өрхийг 80,000 тн сайжруулсан түлшээр хангах

Хувилбар 2: СХД-ийн 2,3,5,6,7,9,10,24,25,26 нийт 10 хорооны 33,3 өрхийг 100,000 тн сайжруулсан түлшээр хангах

Хувилбар 3: СХД-ийн 2, 3, 4, 5, 6, 7,8, 9,10,11,23, 24, 25, 26, 28, 30, 31 нийт 17 хорооны 49,11 өрхийг 150,000 тн сайжруулсан түлшээр хангах

Хувилбар 4: СХД-ийн 2,3,4,5,6,7,8,9,10,11,23,24,25,26,28,30,31, Баянгол дүүргийн 9,10,21,22,23, Чингэлтэй дүүргийн 7,8,9,10,11 нийт 27 хорооны 66,628 өрхийг 200,000 тн сайжруулсан түлшээр хангах .

Судалгаанд үндэслэн агаарын чанарыг сайжруулах бүсэд амьдарч байгаа зорилтот бүлгийн иргэдэд 1700 тонн түлш нийлүүлэх гэрээг “Баялаг Эрдэнэ Цом” ХХК-тай 2017 оны 06 сарын 30-ны өдөр байгуулсан. “Баялаг Эрдэнэ Цом” ХХК нь Говьсүмбэр аймагт байдаг бөгөөд тус аймгийн Сүмбэр /Чойр/ сумын нутаг дэвсгэрт малын гоц халдварт шүлхий өвчин гарсны улмаас тус компани гэрээт ажлыг бүрэн гүйцэтгэж чадалгүй Нийслэлийн Нийгмийн халамжийн газраас ирүүлсэн нэрсийн дагуу 473 тонн түлшийг зорилтот бүлгийн иргэдэд нийлүүлэн хүлээлгэн өгсөн.



Зураг.9. Зорилтот бүлгийн иргэдэд сайжруулсан түлш нийлүүлсэн нь.

Нийслэлийн өмчийн барилгыг төвлөрсөн дулаан хангамжид холбох ажлын хүрээнд:

Төвийн дулаан хангамжийн шугам сүлжээнээс алслагдсан барилгууд, хатуу түлшээр галладаг 22 хорооны цогцолбор барилгын судалгааг шинэчлэн гаргаж мэдээллийн сан үүсгэн ажилласан.

Халаалтын зуухнуудыг үе шаттайгаар төвлөрсөн дулааны шугам сүлжээнд холбох ажлын хүрээнд БХЯ, ЦЕГ, УБЗАА зэрэг байгууллагуудаас техникийн нөхцөл, ажлын даалгавар нь бэлэн болсон ажлуудыг судлан нэгтгэсэн.

Нийслэлийн төсвийн 2018 оны хөрөнгө оруулалт “Утаагүй Улаанбаатар хөтөлбөр”-ийн хүрээнд 4.032 тэрбум төгрөгөөр 10 барилгыг төвлөрсөн дулаан хангамжид холбох ажлыг эхлүүлсэн. Үүнд:

- Баянзүрх дүүргийн 4-р хороонд байрлах зэвсэгт хүчний ...дугаар ангиудыг дулааны шугамд холбох ажил бүрэн дууссан. Гүйцэтгэл 100 хувьтай байна.
- Баянзүрх дүүргийн 8-р хороонд байрлах Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн газар шорооны ажил дуусч шинээр шугам татах ажлын явц 60 хувьтай явагдаж байна.
- Баянзүрх дүүргийн 8,17 дугаар хорооны 6 иргэн, 13 аж ахуйн нэгжийн барилгын гадна дулаан хангамжийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2018 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зарлаж, 2018 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр нээлт хийсэн. НХААГ нь 2018 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр НХОГ-т гэрээ байгуулах зөвлөмжийг хүргүүлсэн. Гэрээг 2018 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр байгуулсан.
- Сонгинохайрхан дүүргийн 7-р хорооны “Хилчин хотхон”-ы барилгыг төвлөрсөн дулаан хангамжид холбох ажлын зургийн даалгаварыг боловсруулуулахаар 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 02/595 дугаар албан бичгээр Нийслэлийн Хот төлөвлөлт ерөнхий төлөвлөгөөний газрын инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтэст хүргүүлж, тус газраас зураг төслийг боловсруулах даалгавар батлагдан ирж, 2018 оны 12 дугаар сарын 11 өдрийн 02/643 дугаар албан бичгээр НХОГ-т хүргүүлээд байна.

Дээрх барилгууд төвлөрсөн дулаан хангамжид холбогдсоноор 14485 тн/жил түүхий нүүрсний хэрэглээг бууруулах юм. Энэ нь тухайн усан халаалтын зуухнуудаас агаарт хаягдах тоосонцрын хэмжээ 114 тн-оор, хүхрийн давхар ислийн хэмжээ 113 тн-оор, азот 34 тн-оор тус тус бууруулж байна.

Иргэдэд экологийн боловсрол олгох зорилтын хүрээнд:

1. 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан “Утааг бууруулах технологийн шийдэл” үзэсгэлэнд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг оролцуулах ажлыг зохион байгуулж ажилласан. Тус үзэсгэлэнд 50 гаруй аж ахуй нэгж, хувь хүн оролцож цахилгаан халаагуур, боловсруулсан хийн түлш, гэрийн дулаалга, шалны ялтсан халаагуур, агаар шүүгч, төрөл сайжруулсан болон цахилгаан зуух, цахилгаан хэмнэгч зэрэг технологийн шийдлийг танилцуулж, холбогдох мэдээллээр хангасан байна.



Зураг 10. “Утааг бууруулах технологийн шийдэл” үзэсгэлэнд оролцож байгаа нь.

2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг сурталчлах, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний бодлого, үйл ажиллагааг мэдээлэх, тус салбарт хийж хэрэгжүүлэх иргэдийн шинэ санал санаачлага, гомдол хүсэлтийг бүртгэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яам 2018 оны 03 дугаар сарын 15-аас эхлэн 03 дугаар сарын 21-нийг дуустал Ус, цаг уур орчны шинжилгээний газарт зохион байгуулсан “Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын нээлттэй өдөрлөг”-т оролцон Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газрын хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, холбогдох эрх зүйн бичиг баримт, гарын авлага материалыг иргэдэд түгээн үйл ажиллагаагаа танилцуулж ажиллалаа. Өдөрлөгт БОАЖЯ-ны харьяа байгууллагууд оролцож өөр өөрсдийн чиглэлээр мэдээлэл өгөхөөс гадна хөндлөнгийн судалгааны байгууллага нээлттэй өдөрлөгт хүрэлцэн ирсэн иргэдийн санал, гомдлыг бүртгэлжүүлж, цаашдын үйл ажиллагаагаа хэрхэн сайжруулах талаар зөвлөмж хүргүүлсэн.



Зураг 11. “Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын нээлттэй өдөрлөг”-т оролцож үйл ажиллагаагаа танилцуулав.

3. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр танин мэдэхүйн 3 төрлийн шторкыг “Нийслэл Дэлгэц” ХХК-ны Сүхбаатарын талбайн урд байрлах дэлгэцээр 2017 оны 12 сарын 20-ноос 2018 оны 03 дугаар сарын 31 хүртэл хугацаанд өдрийн 3 удаагийн давтамжтайгаар цацаж иргэдэд мэдээлэл хүргэж ажилласан.
4. “Агаар орчны бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын эмхэтгэл”-ийг Нийслэлийн Байгаль орчны газар, Нийслэлийн Үйлдвэрлэл инновацийн газар, Нийслэлийн Тээврийн газар, “Улаанбаатар Цэвэр агаар” төсөл зэрэг

байгууллагуудтай хамтран гаргаж дүүргүүдийн хэсгийн ахлагч, олон нийтэд мэдээлэл хүргэн ажилласан.



5. Гэр хорооллын сургууль, цэцэрлэгийн дотоод орчны агаарын чанарыг сайжруулах, иргэд олон нийтэд мэдээлэл хүргэх зорилгоор танин мэдэхүйн зурагт хуудас бэлтгэн 5000 ширхэгийг тараасан.



6. “Хөгжлийн түлхүүр эмэгтэйчүүд” ТББ-тай хамтран агаарын бохирдлыг бууруулах зарим арга хэмжээний талаарх хэлэлцүүлгийг 2018 оны 02 дугаар сарын 09-ноос 24 –ны өдрийг хүртэл зохион байгуулсан.
7. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 43, 62 дугаар тогтоол, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/72-А/174 дүгээр хамтарсан тушаал/захирамжаар баталсан “Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журам”-ын хэрэгжилтийг хангуулах зорилгоор агаар бохирдуулагч томоохон суурин эх үүсвэр ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад Агаарын тухай, Эрчим хүчний тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Хог хаягдлын тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан журам, стандарт, тогтоол шийдвэрийн талаар мэдээлэл өгч, халаалтын зуухны ашиглалт, үйлчилгээний талаар үзүүлэх сургалтыг Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газраас Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Эрчим хүчний зохицуулах зөвлөл, Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, Ану сервис ХХК-тай хамтран Хан-Уул дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 118 дугаар сургуулийн “Ану сервис” ХХК-ийн харьяа халаалтын зуухны байгууламжийг түшиглэн “Бид нэг агаартай” сэдэвт үзүүлэх сургалтыг 2018 оны 05 дугаар сарын 25-ны өдөр зохион байгууллаа.

Сургалтад халаалтын зуух ашиглагч 41 аж ахуйн нэгж, байгууллагын 69 захирал, ажилтнуудын төлөөлөл оролцсон бөгөөд “Засгийн газрын 2018 оны тогтоол, шийдвэр, түүнийг хэрэгжилтийг ханган ажиллах”, “Агаарын бохирдлын хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл, ахуйн тухай хууль, дүрэм журам, стандартын хэрэгжилт, тулгамдаж буй асуудал”, “Бага чадлын зуухны техник ашиглалт”, “Нүүрсний хэрэглээ” зэрэг илтгэлүүдийг холбогдох байгууллагын хэлтсийн дарга, улсын /ахлах/ байцаагчид танилцуулж, агаарын бохирдлын эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээ болон цаашдын хандлагын талаар нээлттэй ярилцсан нь ач холбогдолтой байлаа.



Зураг 12. Хан-Уул дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 118 дугаар сургуулийн халаалтын зуухны байгууламжийг түшиглэн зохион байгуулсан “Бид нэг агаартай” сэдэвт үзүүлэх сургалтыг үеэр.

8. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 43, 62 дугаар тогтоолууд, Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Бид нэг агаартай” дэвшилтэт техник, технологийн үзэсгэлэнг 2018 оны 10 дугаар сарын 11, 12 -ны өдрүүдэд Сүхбаатарын талбайд зохион байгууллаа. Үзэсгэлэнд төрийн 12 байгууллага, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 50 орчим аж ахуй нэгж, төрийн бус байгууллагууд оролцуулж, иргэдэд агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн дэвшилтэт техник, технологиудыг сурталчлан мэдээлэл өглөө.



Зураг 13. “Бид нэг агаартай” дэвшилтэт техник, технологийн үзэсгэлэн.

Үзэсгэлэнгийн үеэр Засгийн газраас агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээний талаарх иргэд олон нийтийн хандлагыг тодорхойлох зорилгоор 100 иргэдээс судалгаа авсан. Судалгаагаар Агаарын бохирдлыг голлох эх үүсвэрийн талаар иргэд түүхий нүүрсний хэрэглээ болохыг онцолж түүнийг хязгаарлахыг судалгаанд оролцсон иргэдийн 90 хувь дэмжихийн зэрэгцээгээр агаарын бохирдлыг бууруулах хамгийн зөв гарц бол гэр хорооллын газрыг орон сууц худалдан авахад урьдчилгаа болгох төслийг нэрлэсэн.



График 1. Агаарын бохирдлын эх үүсвэр /иргэдээс авсан судалгааны дүн/

Агаарын бохирдлын гол эх үүсвэрийн талаар авсан мэдээлэлд нийт санал асуулгад оролцсон иргэд гэрийн зуух 36%, автотээврийн хэрэгслээс 25%, дугуй, хог шатаадаг айл өрх-18%, эзэлдэг Усан халаалтын зуухнаас 4%, хөрснөөс дэгдэх тоос, шороо-17%-ийг үүсгэдэг гэж тус тус хариулсан байна.



График 2. Түүхий нүүрс хэрэглэхийг хориглон шийдвэрийн талаарх иргэдийн байр суурь / судалгааны дүн/

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоолоор түүхий нүүрсийг 2019 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн хориглох арга хэмжээг нийт асуулгад оролцсон иргэдийн 90% нь дэмжиж байна гэж хариулсан. Нийслэлийн Агаарын

бохирдлыг бууруулах газрын үйл ажиллагааг санал асуулгад оролцсон иргэдийн 42 хувь нь дунд зэрэг ажиллаж байна гэж дүгнэсэн байна.

9. Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газар Япон Улсын “ЖАЙКА” олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн “Агаарын бохирдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх” төслийн хүрээнд агаарын чанарын мэдээ, мэдээллийг өдөр тутам багш ажилчид, сурагчдад хүргэх, хотын агаарын чанарын хэмжилтийн мэдээллийг уншиж бохирдлын хэмжээ ямар төвшинд байгаа, эрүүл мэндээ хэрхэн хамгаалах чадварыг эзэмшүүлэх зорилгоор агаарын чанарын мэдээ, мэдээллийг дамжуулах дэлгэцийг БГД-ийн Сэтгэмж, Оюуны ундраа, Шинэ Эрин, 28, БЗД-ийн Амгалан, 9, 21, 68, 48, 84, ЧД-ийн 57, 72, 49, 39, 17, 24, ХУД-ийн 7, 118, 15, 60, СХД-ийн 105, 42, 82, 81, 62, 67, 76, 65, 9, СБД-ийн 58, 6, 16, 29, 4 нийт 35 ерөнхий боловсролын сургуульд суурилуулсан.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/387 дугаар тушаалаар “Агаарын чанарын индексээр агаарын чанарыг үнэлэх, мэдээлэх журам” шинэчлэгдэн баталсантай холбогдуулан нийслэлийн агаарын бохирдол ямар төвшинд байгааг агаарын чанарын индексээр 6 ангилан, ангилал тус бүрт харгалзах индексийн тоон үзүүлэлт, өнгөт тэмдэглэгээ, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тодорхойлсон. Шинэчлэн баталсан журмын хүрээнд дээрх сургуулиудад суурилуулсан агаарын чанарын мэдээ, мэдээлэл дамжуулах дэлгэцийн хэвийн үйл ажиллагааг хангах, шинэчлэн баталсан журам, мөн агаарын бохирдлоос эрүүл мэндээ хамгаалах талаар 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Чингэлтэй дүүргийн Мэдээлэл инновацын төвд сургалт зохион байгуулж ажиллалаа.



Зураг 14. Агаарын чанарын индексийг таниулах, агаарын бохирдлоос эрүүл мэндээ хамгаалах талаар явуулсан сургалтын үеэр.

10. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах зорилтот бүлгийн гэр бүл, хүүхдүүдийг урьдчилан сэргийлэх “Бид нэг агаартай” сургалт мэдээллийн нэгдсэн удирдамжийг Нийслэлийн Засаг даргын ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогчоор батлуулан Сонгинохайрхан дүүргийн агаарын чанарыг сайжруулах бүсийн 8 хорооны /7,8,9,11,24,25,26,28/ нутаг дэвсгэрийн Ерөнхий боловсролын сургуулийн 6-9 дүгээр бүлгийн сурагчдад зориулсан сургалтыг үе шаттайгаар зохион байгуулсан.
11. Гэр хорооллын сургууль, цэцэрлэгийн дотоод орчны агаарын чанарыг сайжруулах, иргэд олон нийтэд мэдээлэл хүргэх зорилгоор танин мэдэхүйн зурагт хуудас бэлтгэн 5000 ширхэгийг тараасан.
12. 2018 оны 09 дүгээр сарын 04, 05-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Монгол улсын нүүрсний салбарт хөрөнгө оруулалт татах, шинэ техник технологи нэвтрүүлэх,

нүүрсний экспорт, худалдаа, тээвэр ложистикийг сайжруулах, Азийн зах зээлд Монголын нүүрсний салбарын өрсөлдөх чадварыг бэхжүүлэх зорилго бүхий 8 дахь удаагийн “Coal Mongolia 2018” форум хэлэлцүүлэгт Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газрын мэргэжилтэн Г.Даваажаргал “Улаанбаатар хотын агаарын бохирдол” сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлэг зохион байгуулсан.Тус форумд НЗДТГ, Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газрын зүгээс “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” Монгол Улсын Засгийн газрын 62 дугаар тогтоолыг форумд оролцогчид танилцуулах, тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний талаарх мэдээлэл бүхий үзэсгэлэн гаргаж амжилттай оролцсон.

13. Улаанбаатар хотын агаар, орчны бохирдлыг бууруулах, агаарын чанарыг сайжруулах хүрээнд хэрэгжүүлж байгаа ажлыг иргэд, олон нийтэд танилцуулах зорилгоор “Агаар, орчны бохирдлыг бууруулахад иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт нээлттэй хаалганы өдөрлөгийг Баянгол, Хан-уул, Баянзүрх дүүрэгт тус тус зохион байгуулан ажилласан.
14. Сонгинохайрхан дүүргийн агаарын агаарын чанарыг сайжруулах бүсийн 8 хорооны /7,8,9,11,24,25,26,28/ нутаг дэвсгэрийн Ерөнхий боловсролын сургуулийн 6-9 дүгээр бүлгийн сурагчид, зорилтот хэсгийн гэр бүл, хүүхдүүдэд агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх сургалт, өдөрлөгийг Нийслэлийн Хүүхэд гэр бүл хөгжлийн газартай хамтран зохион байгуулсан.
15. Сайжруулсан түлшний давуу талыг харуулсан 3 төрлийн шторк бэлтгэж TV5, UBS, MNC, C1, TM, SBN, 25TV, STAR TV зэрэг телевизүүдээр 2018 оны 08 дугаар сарын 14-өөс 09 дүгээр сарын 15 –ны хооронд өдөрт 5 удаагийн давталттай цацаж олон нийтэд мэдээлж ажилласан.
16. Дулаан алдагдлыг багасгахыг уриалсан “Гэр байшингаа дулаалцгаая” уриатай 3 төрлийн шторкийг БОАЖЯ-тай хамтран бэлтгэж нийтийн тээврийн автобуснуудад байрлах мэдээллийн дэлгэцээр цацаж байна.
17. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороотой хамтран “Гэр, байшингаа дулаалцгаая” гэсэн уриатай хэвлэмэл зурагт хуудас 100 000 ширхэгийг хэвлэн гаргаж дүүргүүдэд хүргүүлсэн.

Агаар бохирдуулагч эх үүсвэрийн цахим мэдээллийн санг ашиглан тухайн жилийн өөрчлөлтийг нэгдсэн мэдээллийн санд оруулж, өөрчлөлтийг бүртгэх ажлын хүрээнд:

Улаанбаатар хотын агаарын бохирдлын суурин эх үүсвэр “ердийн галлагаатай 15 кВт хүртэл хүчин чадалтай зуух”, “усан халаалтын 16-100 кВт хүчин чадалтай зуух”, “усан халаалтын 101 кВт-аас дээш хүчин чадалтай зуух”, “дулааны цахилгаан станц” болон хөдөлгөөнт эх үүсвэр болох дизель түлш, шатахуунаар ажилладаг бүх төрлийн авто тээврийн хэрэгсэл зэрэг агаарын бохирдлын бүхий л эх үүсвэрүүдийн мэдээллийн нэгдсэн системийн хэрэглэгчдэд зориулсан сургалтыг “Бид солюшн” ХХК-тай хамтран Нийслэлийн 9 дүүргийн агаарын бохирдол хариуцсан мэргэжилтнүүд, бүх хороодын мэргэжилтнүүдийг хамруулан 2018 оны 02 дугаар сарын 20-24-ний өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтад нийт 226 мэргэжилтнүүд хамрагдсан.

Нийслэлийн агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэлийг 2018 онд 2 удаа зохион байгуулсан.

1. НЗД-ын 2018 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/398 дугаар захирамжийн дагуу бага, дунд оврын халаалтын зуухны байгууламжийн дахин бүртгэл тооллогын ажлыг

2018 оны 6 дугаар сард зохион байгуулсан. Тус тооллогын ажлаар нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд 15-100кВт хүчин чадалтай 2397 зуух бүртгэгдсэн.

2. БОНХС-ын 2014 оны А/181 дүгээр тушаалаар баталсан "Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах журам"-ын дагуу агаарын бохирдлын эх үүсвэрийн бүртгэл тооллогын ажлыг 10-12 дугаар сард зохион байгуулсан. Тус тооллогын ажлаар нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд 3-15кВт хүртэлх хүчин чадалтай 171619 ахуйн хэрэглээний зуух, 15-100кВт хүчин чадалтай нам даралтын 2397 халаалтын зуух, 100кВт-аас дээш хүчин чадалтай 200 байгууламжийн 384 уурын болон усан халаалтын зуух, 501683 тээврийн хэрэгсэл бүртгэгдлээ.

Агаар бохирдуулагч эх үүсвэр тус бүрийн судалгаанд үндэслэн хортой бодисуудын тархалтын загварчлалыг гаргаж, тэдгээрийн нөлөөллийг тодорхойлох ажлын хүрээнд:

Агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэлийг 2018 онд 2 үе шаттай зохион байгуулсан. Үүнд:

1-р үе шат: НЗД-ын 2018 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/398 дугаар захирамжийн дагуу бага, дунд оврын халаалтын зуухны байгууламжийн дахин бүртгэл тооллогын ажлыг 2018 оны 06 дугаар сард зохион байгуулсан.

2-р үе шат :БОНХС-ын 2014 оны А/181 дүгээр тушаалаар баталсан "Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах журам"-ын дагуу агаарын бохирдлын эх үүсвэрийн бүртгэл тооллогын ажлыг 10 дугаар сарын 08-аас 12 дугаар сарын 15-ныг хүртэлх хугацаанд зохион байгуулсан. Тооллогын дүнг нэгтгэн ажил хийгдэж байгаа бөгөөд тооллогын үр дүнд үндэслэн агаарын бохирдлын эх үүсвэрийн инвенторын жилийн тайланг гаргана. Агаарын бохирдлын эх үүсвэрийн инвенторын жилийн тайлан гарсны дараа PM10, SO2, NOx бодисуудын тархалтын загварчлалыг гаргаж, тэдгээрийн нөлөөллийг тодорхойлно. Агаар дахь эдгээр бохирдуулах бодисуудын агууламж, нөлөөллийн тооцоог 2019 оны 1-р улиралд хийхээр бэлтгэл ажил хийгдэж байна.

Нийтийн тээврийн дизель автобусанд утааны тортог шүүгч DPF суурилуулах ажлын хүрээнд:

Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 128 дугаар тушаалаар автотээврийн хэрэгслээс ялгарах утааг багасгах талаар санал, холбогдох шийдвэрийн төсөл, төлөвлөгөө боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсэг Япон Улсын олон улсын хамтын ажиллагааны "ЖАЙКА" байгууллагатай хамтран нийтийн зорчигч тээврийн 24 автобусанд суурилуулсан. Нийтийн тээврийн автобусанд DPF суурилуулах ажлын хүрээнд нэг автобусыг 2018 оны 6-р сарын 15-26-ны хооронд засварт ороогүй, орсон болон DPF суурилуулсан, суурилуулаагүй эсэхээр тус тусад нь замын хөдөлгөөнд оролцуулж (NOx, PM)-ын хэмжилт хийсэн. Хаягдал утааны хэмжээ болон шатахуун зарцуулалтыг засварт орсон, ороогүй, DPF суурилуулсан, суурилуулаагүй байдлуудаар нь харьцуулахад DPF суурилуулсан хэмжилтээр NOx, PM-ын буурсан үр дүнтэй байсан. DPF-гүй засварт орсон (тос сольж, агаар шүүгчийг сольсон) үеийг DPF-гүй засвар үйлчилгээ хийгдээгүй үетэй харьцуулан үзэхэд NOx нь 1.43гр/км/тонн-оор буюу 3 хувиар буурсан, PM нь 0.080гр/км/тонн 11 хувиар, шатахуун зарцуулалт 0.37л/км 9 хувиар буурсан. Үүнээс харахад засвар үйлчилгээг тогтмол хийх нь автомашинаас ялгарах бохирдлыг бууруулахад тодорхой үр нөлөөтэй гэсэн дүгнэлтэнд хүргэж байна. DPF-тэй

засвар хийсэн үеийг DPF-гүй засвар хийсэн хэмжилттэй харьцуулахад NOx 1.36гр/км/тонн 5 хувиар, PM нь 0.008гр/км/тонн 90 хувиар тус тус буурсан, шатахуун зарцуулалт 0.35л/км 4 хувиар буурсан байна.

Хяналт-шалгалт, судалгааны ажлын хүрээнд:

- 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн анги танхим, эмнэлгийн эрчимт эмчилгээ, хүүхдийн тасагт олгосон агаар цэвэршүүлэгчийн ашиглалтын байдалд хяналт тавих ажлын удирдамжийн дагуу 2018 оны 02 дугаар сарын 19-ний өдрөөс 03 дугаар сарын 01-ний өдрийг дуустал Нийслэлийн 6 дүүргийн 120 хороодын 6287 агаар цэвэршүүлэгчийн төхөөрөмжид хяналт шалгалт хийж нийт 52 ажиллуулаагүй төхөөрөмжүүдийг хэвийн ажиллагаанд оруулж 5 эвдрэлтэй төхөөрөмжийг холбогдох байгууллагуудаар солиулж алдаа дутагдлыг арилгуулан ажилласан.
- Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Хэсэгчилсэн Инженерийн хангамжийн удирдах газар, төвийн 6-н дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэд бүтэц тохижилтын хэлтэс хамтран Нийслэлийн нутаг дэвсгэрт уурын болон усан халаалтын зуух ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад “Агаарын тухай”, “Агаарын бохирдлын төлбөрийн тухай”, “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай”, “Усны тухай”, “Газрын тухай”, “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай”, “Эрчим хүчний тухай” хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан тогтоол шийдвэр, журам, стандарт, захирамжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, эрсдлээс урьдчилан сэргийлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, халаалтын зуухны яндангаас ялгарах хаягдал утаанд хийн хэмжилт хийж магадлан итгэмжлэх, стандарт хангахгүй зуухнуудыг шинэчлүүлэх санал, дүгнэлтийг холбогдох газарт хүргүүлэн ажиллалаа.

Нийслэлийн төвийн 6 дүүрэгт 188 бие даасан дулааны эх үүсвэрийн төвд нийт 345 халаалтын зуух байгаа бөгөөд тус төвүүдийн 41 нь дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй. Тэдгээрийн жилийн нүүрсний хэрэглээ 171,0 мянган тонн байгаа бөгөөд тэдгээрийн 47 орчим хувь Налайх, үлдсэн 53 хувь нь Багануурын нүүрс хэрэглэж байна. Мөн халаалтын зуухны хэрэглээний дийлэнх олонх буюу 30 хувь нь боловсролын салбарт харьяалагддаг.

Нийслэлийн Засаг даргын А/805 захирамжийг үндэслэн Ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогчоор батлуулсан удирдамжийн дагуу 2017 оны 11 дүгээр сарын 20-ний өдрөөс 2018 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд агаар бохирдуулагч томоохон эх үүсвэрийг магадлан итгэмжлэх, хяналт шалгалт хийсэн. Энэ халаалтын улиралд буюу 2017–2018 онд 100 кВт-аас дээш хүчин чадалтай зуух ашигладаг ААНБ-ын магадлан итгэмжлэх хяналт шалгалтын дүнгээр Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт 188 аж ахуйн нэгж байгууллагын 345 халаалтын зуух бүртгэгдэж шалгагдав.

Хүснэгт 4. Халаалтын болон уурын зуухны түлшний хэрэглээ

Үндсэн мэдээлэл		БГД	БЗД	СХД	СБД	ХУД	ЧД	Нийт дүн
Зуухны үндсэн мэдээлэл	Байгууламжийн тоо	8	65	36	16	36	27	188
	Зуухны тоо	9	123	72	29	66	46	345
Түлшний хэмжээ	Багануур	1600	48892	21540	3802	26757	7304	109895
	Налайх	120	18422	16160	1673	10260	6514	53149
	Бусад	0	4456	1000	900	1600	650	8606
	Нийт хэрэглээ	1720	71770	38700	6375	38617	14468	171650

Хүснэгт 5. Халаалтын болон уурын зуухны ашиглалтын хэлбэр

№	Салбарын ангилал	Халаалтын зуухны газар	
		Тоо	%
1	Үйлдвэрлэл	41	21.8
2	Барилга, орон сууц	22	11.7
3	Худалдаа	22	11.7
4	Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	7	3.7
5	Зочид буудал, зоогийн газар	7	3.7
6	Үл хөдлөх хөрөнгө, түрээс	1	0.5
7	Боловсрол	58	30.9
8	Эрүүл мэнд	5	2.7
9	Бусад	25	13.3
	Дүн	188	100

Хүснэгт 6. Халаалтын болон уурын зуухны тусгай зөвшөөрөлтэй эсэхийн судалгаа

Д/д	Дүүрэг	Зуухны газрын тоо	Тусгай зөвшөөрөлтэй		Тусгай зөвшөөрөлгүй	
			Төр	Хувийн хэвшил	Төр	Хувийн хэвшил
1	Баянгол	8	1	0	0	7
2	Баянзүрх	65	6	6	16	34
3	Сонгинохайрхан	36	2	8	16	6
4	Сүхбаатар	16	1	1	4	11
5	Хан-Уул	36	3	5	11	20
6	Чингэлтэй	27	2	6	9	13
Нийт		188	15	26	56	91

“Агаар бохирдуулагч томоохон аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийж, магадлан итгэмжлэх” ажлын хүрээнд уурын болон халаалтын зуухнаас ялгарах агаар бохирдуулах бодисын хэмжилтийг 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 2018 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэсэн. Энэхүү хэмжилтийг хийж гүйцэтгэхэд Монгол Улсын “0-4,2МВт хүртэлх чадалтай ус халаах зуухны техникийн ерөнхий шаардлага “ MNS5043:2016, “ДЦС-ын уурын ба ус халаах зуухны ашиглалтын үед агаар мандалд хаях утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, тэдгээрийг хэмжих арга” MNS 5919:2008 стандартуудыг тус тус баримтлан нийт 40 байгууллагын халаалтын зууханд хэмжилт хийхэд, тэдгээрийн 82.5 хувь буюу 33 байгууллагын зуух шаталтаас ялгарах хорт хийн стандартыг хангаагүй байна.

Хүснэгт 7. Хэмжилтийн дүн (2018 оны 01-04-р саруудад хийсэн хэмжилт)

№	Зуух эзэмгшигч байгууллагын нэр	УХЗ-ны нэр, хүчин чадал	Хаяг, байршил	Бохирдуулагч бодис /мкг/м3/-ээр				Эко тоноглол	Нүүрсний төрөл
				SO ₂	NO _x	CO	TSP		
1	Эм СиЭс Кока Кола ХХК	MNS5919:2008		1620	1150	1030	13000	Нойтон үнс баригч	НН
		DZL-6т/ц	БЗД Үйлвэрийн байранд	830	76	1956	2305		
2	Эм СиЭс Тайгер ХХК	MNS5919:2008		1620	1150	1030	13000	Нойтон үнс баригч	НН
		DZL-6т/ц	БЗД Үйлдвэрийн байранд	1523	245	1957	1635		
3	117-р сургууль /ХИХУГ/	MNS5043:2016		800	450	5000	600	Багц циклон хуурай үнс баригч	НН
		Китурами 0,3МВт	СБД	710	128	5185	385		

			Сургуулин байр						
4	Дако ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	байхгүй	БН
		НРЖ-0,25 МВт	БЗД Сэлбэг ХТ	1112	176	919	290		
5	Дөлгөөн дэлгэрэх ХХК	MNS5043:2016		1000	500	9700	225	байхгүй	БН
		Дакон 0,045МВт	ХУД Ачаа хүргэлтийн байр	273	260	8894	1137		
6	Дулаан техник үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн	MNS5043:2016		800	450	5000	600	байхгүй	БН
		SHG-0.49Мвт	СБД Хүрээлэн байр	220	25	840	120		
7	Есөн-Од ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	байхгүй	БН
		LSG 0,14МВт	СБД Ажлын байранд	196	116	5387	435		
8	Жөн Юан ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	Циклон болон усан давхар шүүлтүүр	НН
		DZL 1.4МВт	БЗД Оффис	1795	238	1795	181		
9	Проджи ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	Багц циклон хуурай үнс баригч	БН
		Эко стар 0,3МВт	ХУД Эвридэй ХТ	411	155	4187	669		
10	Сэйли фүүд ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	Багц циклон хуурай үнс баригч	БН
		LSCO 0,4МВт	СХД Үйлдвэрлэлийн байранд	70	41	1688	670		
11	Талст эрчим ХХК	MNS5043:2016		600	400	4000	400	Циклон болон усан давхар шүүлтүүр	НН
		DZL 1,4МВт	СХД Хороо, эмнэлэг, сургуулийн байр	1638	232	1967	329		
12	Төмөр металик ХХК	MNS5043:2016		1200	700	9800	130	Байхгүй	БН
		УХЖЗ гар хийц	БЗД 0,010 МВт	769	112	14781	215		
13	Шинэ Гантиг ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	Циклон болон усан давхар шүүлтүүр	БН
		МУХТ	БЗД	649	231	2130	103		

		0,7МВт	Үйлдвэр байр						
14	Эко Могул ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	Циклон болон усан давхар шүүлтүүр боловч ажиллагаагүй	НН
		МУХТ 0,7 МВт	БЗД Амгалан ХТ	189	55	9333	1816		
15	УБ буян ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	Багц циклон хуурай үнс баригч	НН
		Терморобот 0,25МВт	СХД-32 хороо	1307	179	10233	779		
16	Модерн Классик фурнитур ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	байхгүй	БН
		WSG 0,25МВт	БЗД-9-р хороо	1825	173	5153	690		
17	Миний дэлгүүр ХТ	MNS5043:2016		800	450	5000	600	байхгүй	БН
		НРЖ-0,15МВт	БЗД 9-р хороо Шар хад	426	159	2942	803		
18	Ватикан сүм	MNS5043:2016		800	450	5000	600	Багц циклон хуурай үнс баригч	НН
		СКД СКД-0,15МВт	СБД 14-р хороо	656	156	4231	113		
19	Ану сервис ХХК 35 сургууль	MNS5043:2016		800	450	5000	600	Циклон болон усан давхар шүүлтүүр	НН
		Карборот 0,3МВт	СБД 14-р хороо	553	60	3341	340		
20	Бэх бат цайз ХХК	MNS5043:2016		1000	500	9700	225	байхгүй	БН
		УХЖЗ 0,04МВт	СБД 14-р хороо	246	151	13605	1113		
21	Бага баян энхийн төлөө цогцолбор	MNS5043:2016		800	450	5000	600	Циклон болон усан давхар шүүлтүүр	НН
		DZL 1.4МВт	СБД-19-р хороо	1331	172	3157	348		
22	Паркнайн ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	Багц циклон хуурай үнс баригч	НН
		Прометей ХХК 0,25МВт	ХУД 8-р хороо	1849	246	5336	422		
23	Стимо ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	байхгүй	БН
		WSG-0.25МВт	БЗД 9-р хороо	1074	90	7623	63		
24	Хуаймейда ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	Багц циклон хуурай үнс баригч	НН
		LSG 0.18МВт	БЗД 9-р хороо	965	229	1942	374		
25	Санжат ХХК	MNS5043:2016		800	450	5000	600		НН

		МУХТ 0,5МВт	СБД-14-р хороо	1283	236	3142	270	Багц циклон хуурай үнс баригч	
26	Витсамо ХХК	MNS5919:2008		1620	1150	1030	13000	Циклон болон усан давхар шүүлтүүр	АТ
		DZL 1,25МВт	БЗД-9-р хороо, үйлдвэри йн байр	1107	146	4726	2253		
27	Янмал ХХЗ	MNS5043:2016		1000	500	9700	225	байхгүй	НН
		USPOR 0,09МВт	СБД-ийн 20-р хороо	689	88	23213	620		
28	Монгол эко мах ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	Циклон болон усан давхар шүүлтүүр	БН
		CWSN 0.7 МВт	СХД-ийн 32-р хороо	653	232	1736	365		
29	Бест сервис ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	байхгүй	НН
		LS60 0.056 МВт	БГД	144	259	6973	194		
30	Говьхангай мебель ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	байхгүй	
		Одкон НР 0,15МВт	ЧД 19-р хороо	42	25	8572	725		
31	Мяралзаа ХХЗ	MNS5043:2016		800	450	5000	600	байхгүй	БН+А Т
		УХЖЗ 0,12МВт Хятад	БЗД 12-р хороо	22	100	8240	74		
32	Чанар авто угаалга	MNS5043:2016		800	450	5000	600	байхгүй	БН
		УХЖЗ 0,04МВт	СХД 28-р хороо	36	20	7973	107		
33	Говь түшээ ХХК	MNS5043:2016		800	450	5000	600		БН
		CLHG 0.7 МВт	БЗД 14-р хороо	5	32	6502	1371		
34	Апекс групп	MNS5043:2016		800	450	5000	600		НН
		CLSG 0.16МВт	БЗД 14-р хороо	844	1	8478	148		
35	155-р цэцэрлэг	MNS5043:2016		800	450	5000	600	байхгүй	НН
		Дакон 0,045МВт	ЧД	7	31	8915	195		
36	174-р цэцэрлэг	MNS5043:2016		800	450	5000	600	байхгүй	НН
		Одкон НР 0,15МВт	ЧД 17-р хороо	193	238	4574	1083		
	Элемент ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	байхгүй	НН

37		Дакон 0,03МВт	СХД	21	173	7041	565		
38	Замбуулин вилаж ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	Багц циклон хуурай үнс баригч	ШГ
		Термо робот 0,6МВт	СБД	1081	68	3628	3200		
39	Мөнгөн пирамид ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	байхгүй	БН
		УХЖЗ 0,06МВт	ЧД 19-р хороо	138	1	16530	123		
40	Үүрд мөнжин бадарна	MNS5043:2016		800	450	5000	600	байхгүй	НН
		УХЖЗ 0,04	СХД Тахилт	288	51	6251	701		
Бохирдуулагч бодис тус бүрийн стандарт хангалтын байдал %-иар				75%	100%	55%	65%	Экологийн нэмэлт төхөөрөмжийг тавих, үнс баригчын арчилгаа үйлчилгээг сайжруулах, нүүрсийг битүү саванд хадгалах	
MNS5043:2016 стандартыг хангаагүй зуухны байгууламжын тоо				33 зуух					

Тайлбар: НН-Налайх нүүрс, ШГ-Шарын голын нүүрс, АТ-Алаг толгойн нүүрс, БН-Багануурын нүүрс

Хүснэгт 8. Хэмжилтийн дүн (2018 оны 10-12-р саруудад хийсэн хэмжилт)


	Зуух эзэмшигч а.а.н.б	MNS стандарт		SO ₂	NO _x	CO	TP	Экологийн тоноглол	Нүүрсн ий төрөл
1	"Цогш" ХХК	MNS5919:2008		1620	1150	1030	13000	Байхгүй	БН
		DZL- 1.4МВт	СБД-14 үйлдвэри йн байр	892	184	3567	1563		
2	"Хаш зүмбэрэл" ХХК	MNS5043:2016		1000	5000	9700	225	Байхгүй	ШТ
		УХЖЗ 15кВт	БЗД	79	151	6105	150		
3	"Найрамдал" ОУХТ	MNS5043:2016		600	4000	4000	400	Нойтон үнс баригч	БН
		DZL- 2.8МВт	СХД	387	199	749	5627		

4	“Алтан жолоо трейд” ХХК-1	MNS5043:2016		800	450	5000	600	Байхгүй	БН
		НРЖ 0,7МВт	БЗД-12 “Сансар” ХТ	585	280	3974	1920		
5	“Алтан жолоо трейд” ХХК-2	MNS5043:2016		800	450	5000	600	Хуурай үнс баригч	БН
		Китурами 0,3	СХД, 22-ын товчоо	615	259	13136	6458		
6	“Мөнхбаясах кейсинг” ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	Нойтон үнс баригч	НН
		Баомин-0,35	СХД, Эмээлт	1056	153	5759	250		
7	“Баттрейд Си” ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	Байхгүй	БН
		НРЖ-025	ХУД, “Чандмань” ХТ	254	205	7162	3417		
8	“Азийн тулгуур” ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	Байхгүй	
		НРЖ 0,25	БЗД Ажлын байр	683	176	7788	268		
9	“Тэмүүлэн-Од” ХХК	MNS5919:2008		1620	1150	1030	13000	Байхгүй	НН
		DZL-1,2МВт	БЗД-23 үйлдвэрийн байр	1733	129	4621	391		
10	“Проджи” ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	Хуурай үнс баригч	БН
		Эко стар 0,3МВт	ХУД Эвэридэй ХТ	195	119	7972	419		
11	87-р сургууль “2лаа хүү” ХХК	MNS5043:2016		600	400	4000	400	Хуурай үнс баригч	БН
		МУХТ1,4М МВт	БЗД	321	164	534	1164		
12	Жанжин клуб “2лаа хүү” ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	Хуурай үнс баригч	НН
		DZL-0.7	БЗД	1231	263	1670	108		

13	Яармаг “2лаа хүү” ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	Хуурай үнс баригч	БН
		DZL-0.7	ХУД	990	337	5129	5186		
14	65-р сургууль “2лаа хүү” ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	Хуурай үнс баригч	БН
		МУХТ-0,7	СХД	1545	383	3625	1968		
15	61-ийн гарам “2лаа хүү” ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	Хуурай үнс баригч	
		МУХТ-0,7	СХД	2187	487	3839	2469		
16	“Бишрэлт трейд” ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	байхгүй	
		НРЖ-25	СХД Велмарт ХТ	254	205	7162	3417		
Бохирдуулагч бодис тус бүрийн стандарт хангалтын байдал %-иар				43.7%	99%	75%	56%	Экологийн нэмэлт төхөөрөмжийг тавих, үнс баригчын арчилгаа үйлчилгээг сайжруулах, нүүрсийг битүү саванд хадгалах, галчыг сургалтанд хамруулах	
MNS5043:2016 стандартыг хангаагүй зуухны байгууламжын тоо				15 зуух					

Тайлбар: НН-Налайх нүүрс, ШГ-Шарын голын нүүрс, АТ-Алаг толгойн нүүрс% БН-Багануурын нүүрс ШТ-Шахмал нүүрс

График 3. Уурын халаалтын зуухнуудын тоосонцрын /TSP/ агууламжийн хэмжээ






График 4. Уурын халаалтын зуухнуудын хүхэрлэг хийн /SO₂/агууламжийн хэмжээ




График 5. Уурын халаалтын зуухнуудын нүүрстөрөгчийн дутуу ислийн агууламжийн хэмжээ

Хяналт шалгалтын ажлын дүнгээс харахад зууханд тохирсон нүүрсийг ашигладаггүй, нүүрс агуулах байргүй, өвлийн улиралд ил задгай овоолготой нүүрсээр галлагаа явуулж байгаа нь тухайн зуухны нүүрсний зарцуулалтыг ихэсгэж улмаар агаарт хаягдах бохирдуулах бодисын ялгарлын хэмжээг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна. Мөн үнс баригч болон хүхэргүйжүүлэгч төхөөрөмжгүй зуух олон байгаа нь галлагаанаас үүдэлтэй хаягдал утаан дахь хүхэр болон тоосны стандартыг хангахгүй байх, галчийн галлагааны ур чадвар зарим

газар хангалтгүй байх зэрэг зөрчил, дутагдал илрүүлэн, илэрсэн зөрчлийг арилгах үүрэг даалгавар өгч, холбогдох арга хэмжээ авч ажилласан.

Тус шалгалтын хүрээнд: Баянгол дүүрэгт 8 аж ахуйн нэгжийн 9 зуух, Баянзүрх дүүрэгт 65 аж ахуйн нэгжийн 123 зуух, Сонгинохайрхан дүүрэгт 36 аж ахуйн нэгжийн 72 зуух, Сүхбаатар дүүрэгт 16 аж ахуйн нэгжийн 29 зуух, Хан-Уул дүүрэгт 36 аж ахуйн нэгжийн 66 зуух, Чингэлтэй дүүрэгт 27 аж ахуйн нэгжийн 46 зуух, хамрагдаж бүртгэгдсэн бөгөөд 56 УХЗ-нуудад хаягдал утааны хэмжилтийг хийж гүйцэтгэж, хэмжилтийн дүнг НМХГ-т хүргүүлсэн.

100кВт-аас дээш хүчин чадалтай халаалтын зууханд магадлан итгэмжлэл явуулах, 100 кВт-аас дээш хүчин чадалтай уурын болон халаалтын зуухнаас ялгарах үнс, тоосонцрын хэмжээг бууруулах ажлын хүрээнд:

100 кВт-аас дээш хүчин чадалтай уурын болон халаалтын зуухны байгууламжуудад 2017-2018 оны өвлийн улиралд хийгдсэн магадлан итгэмжлэх ажлаар нийт байгууламжийн 11,7 хувь нойтон, 37,2 хувь хуурай үнс баригчтай, 5,3 хувь утаа шүүгч катализатортай байна.

Хүснэгт 9. 100 кВт-аас дээш усан халаалттай зуухны тооллогын дүн

	Дүүрэг	Нийт байгууламжийн тоо	Нойтон үнс баригч	Хуурай үнс баригч	Утаа шүүгч, катализатор	Байхгүй
1	Баянгол	8	1	0	1	6
2	Баянзүрх	65	12	14	5	34
3	Сонгинохайрхан	36	3	14	1	18
4	Сүхбаатар	16	0	8	0	8
5	Хан-Уул	36	3	26	1	6
6	Чингэлтэй	27	3	8	2	14
	Нийт	188	22	70	10	86

Нийслэлийн төвийн 6 дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй зөрчил гаргасан аж ахуйн нэгж, байгууллагад үнс баригч тоног төхөөрөмж суурилуулах, нүүрс, үнсний битүүмжилсэн агуулах барих, холбогдох бичиг баримтын бүрдэл хангуулах тухай 206 заалттай 45 албан шаардлага, хэмжилтийн дүнд үндэслэн 40 дүгнэлт гаргаж Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн 20 600.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажиллалаа.



Зураг 15. Халаалтын зуухнуудад магадлан итгэмжлэл явуулж байгаа нь.

Төрийн өмчийн Хэсэгчилсэн Инженер хангамжийн удирдах газрын харьяа 15-н байгууламжийн 32 зуухны судалгааг гаргасан. Дээрх судалгаанаас 10-н байгууламжийн 19 зууханд тоног төхөөрөмж суурилуулах аж ахуйн нэгж, байгууллагыг сонгож, техникийн тодорхойлолтыг боловсруулан Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. Ингээд 10 халаалтын төвийн 19 зууханд шүүлтүүр суурилуулах ажлын хүрээнд 46, 61, 68, 79-1, 102, 114, 104, 117-р сургуулиуд, 6-р цэцэрлэг, Глоб 128 айлын орон сууцны халаалтын зуухнуудад синтетик катализатор бүхий шүүлтүүр суурилуулсан.

Автотээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн шаталтаас ялгарах хорт хийн хяналтын ажлын хүрээнд:

1. Замын цагдаагийн алба, Автотээврийн үндэсний төв, Нийслэлийн Засаг даргын Ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогч нараар 2018 оны 06 дугаар сарын 08-ний өдөр “Автотээврийн хэрэгслийн утааны яндангаас гарах дуу чимээ, ялгарах хаягдал утаан дахь агаар бохирдуулах бодисыг хэмжиж, үнэлгээ дүгнэлт өгөх ажлын удирдамжийг” батлуулан ажилласан. Уг ажлын хүрээнд замын хөдөлгөөнд оролцож буй нийт 1000 гаруй тээврийн хэрэгсэлд хяналт, шалгалт хийсэн. Үүнд: Дизель хөдөлгүүртэй 798, бензин хөдөлгүүртэй 181, хий, цахилгаан хосолмол хөдөлгүүртэй 20 тээврийн хэрэгсэл тус тус хамрагдсан.

Хяналт шалгалтад хамруулсан тээврийн хэрэгслийг стандартын шаардлага хангасан эсэх талаар нь ялган харуулбал зөвшөөрөгдөх хэмжээнээс илүү утаа ялгаруулж буй 625, хэвийн буюу стандартын шаардлага хангасан нь 389 байсан. Стандартын шаардлага хангаагүй авто тээврийн хэрэгсэлүүдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч ажилласан. Зөрчлийн тухай хуулийн дагуу стандартаас илүү утаа ялгаруулж байсан 625 авто тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж байгууллагад торгуулийн арга хэмжээг Замын цагдаагийн албанаас тавьж, зөрчлийг арилгуулах зөвлөмж, зөвлөгөө өгч ажилласан.



Зураг 16. ЗГА-ай хамтран тээврийн хэрэгсэлийн яндангаас гарах хорт хийн утааг хэмжих хяналт шалгалт хийж байгаа нь.

JICA төслийн хүрээнд нийтийн тээврийн хэрэгсэлээс ялгарч буй бохирдлын хэмжээг тодорхойлох, тандалт хийх зорилгоор 51 автобусанд (Таван шар, Ханийн материал, Дүнжингарав, Шар хад) Нийслэлийн Тээврийн газартай хамтран 2018 оны 8 сарын 16 болон 17-ны өдрүүдэд ХОРИБА МЕХА-600S загварын тортог хэмжигч багажаар хэмжилт хийсэн. Хэмжилтийн дүнгээс харахад Улаанбаатар хотод зорчиж байгаа нийтийн тээврийн автобусны 60%-ээс дээш хувийг DEAWOO, HYUNDAI загварын автобуснууд эзэлж байна.

Нийт хэмжилтэд хамруулсан автобуснууд “MNS 5014 дизель хөдөлгүүртэй автомашин-Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга” стандартын шаардлагыг 14 хувь буюу 7 нь хангаж байсан.



Зураг 17. JICA төслийн хүрээнд нийтийн тээврийн хэрэгсэлээс ялгарч байгаа бохирдлыг тодорхойлох тандалт, хэмжилт

Сургууль, цэцэрлэгийн дотоод орчны агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/980, А/1005 дугаар захирамжаар “Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн 1, 2 дугаар бүсэд орших ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн анги, танхим, эмнэлгийн хүүхдийн тасгийн өрөө, тасалгаанд зориулан 5270 агаар цэвэршүүлэгч худалдан авах” гэрээг 9 аж ахуй нэгжтэй байгуулж энэхүү ажлын хүрээнд 125 сургууль, 130 цэцэрлэг, 15 эмнэлэг, 4 асрамжийн газар, 142 өрхийн эрүүл мэндийн төвд нийт 5270 агаар цэвэршүүлэгчийг хүлээлгэн өгсөн.

Мэдээлэл технологийн ажлын хүрээнд:

Байгууллагын цахим хуудсын программыг “Бид солюшн” ХХК-иар бүхэлд нь шинэчлүүлж даргын тушаал, холбогдох мэдээ мэдээлэл, хууль тогтоомж, дүрэм журмыг тухай бүр өөрчлөн байршуулан ажиллаж байна.

Нийслэлийн агаарын чанарын суурин харуулын мэдээг цагт тухайд нь онлайнар www.agaar.mn, www.air.ub.gov.mn, www.aqicn.org сайтуудаар иргэдэд мэдээллэж байгаа бөгөөд суурин харуулын байршил бүрд LCD дэлгэцээр мөн БОАЖЯам, Хангарди ордон, ЦУОШГ-ын үүдэнд нийт 4 ТВ дэлгэцээр, мөн гар утасны “Агаар” аппликейшнээр дамжуулан олон нийтэд шууд хүргэж байна. Суурин харуулуудын мэдээлэл дамжуулах сервер, сүлжээний тохируулгыг холбогдох газруудаар цаг тухайд нь хийлгэж хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэн ажиллалаа.

Албан бичиг, баримтыг олон нийтийн сүлжээгээр дамжуулах болон тусгай программ хангамж ашиглан олон нийтийн сүлжээнд хандахыг хориглож байгаа талаар нийт албан хаагчдад танилцуулан интернет үйлчилгээг Хангарди ордны сүлжээгээр дамжуулан авч, олон нийтийн сүлжээ, онлайн тоглоомын болон видео сан бүхий сайтуудад нэвтрэхгүй байх тохиргоог хийлгэсэн. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүднээс бүх компьютерт “Kaspersky End point 10” антивирусны программ хангамжийн лицензыг авч суулгасан.

ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХИЖУУЛАЛТ, НИЙГМИЙН БАТАЛГАА:

Байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх, сургалтын болон нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын хэрэгжилт

Хүснэгт 10.

Зорилт	№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Зүрилтот түвшин (Тоо хэмжээ, хувь)	Хүрсэн түвшин (Хэрэгжилт ийн хувь, тоо хэмжээ)	Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр гүйцэтгэлээр (мян.төг)	Тайлбар
1. Хүний нөөцийг Чадавхжуулах	1	Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт	Дотоод сургалтын тоо	5-аас дээш	10 удаагийн сургалтад хамрагдсан. 100%	Зохион байгуулагч байгууллага зардлыг хариуцсан.	
			Албан хаагчдын хамрагдсан байдал	80 хувиас дээш	Давхардасан тоогоор 22 албан хаагч хамрагдсан 100%		
			Гадаад сургалтад албан хаагчдын хамрагдсан байдал	20 хувиас дээш	Давхардсан тоогоор 13 албан хаагч хамрагдсан. 100%		
	2	Мэргэшсэн, туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх	3 болон түүнээс дээш жил ажилласан мэргэшсэн боловсон хүчний үзүүлэлт	70 хувиас дээш	Төрийн албанд болон тухайн ажлын байранд нийт 15 албан хаагч ажиллаж байна. 75%		
Хэсгийн дундаж: 93,75%							
2. Албан хаагч-дын Нийгмийн Баталгааг хангах	3	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	Шагнал, урамшуулалд хамрагдсан албан хаагчдын тоо	Гүйцэтгэлээр	Тэмдэглэлт баярын өдрийг тохиолдуулан 9 албан хаагч шагнагдсан. 70%		
			Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан олгох нэмэгдэл, зэрэг дэв, шатлал ахиулах	Гүйцэтгэлээр	4 албан хаагч ажилласан жилийн нэмэгдэл нэмсэн, 4 албан хаагчид цалингийн шатлал ахиулсан 100%		
	4	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байдал	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулга	Сэтгэл ханамж 80 хувиас дээш	Албан хаагчдад албан үүргээ гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай техник тоног төхөөрөмжийг шинээр авч, хугацаа дууссан эд хогшлийг сольсон. 100%	15,155.800 мянган төгрөгийг зарцуулсан	
		Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх		Гүйцэтгэлээр	Албан хаагч бүрт сар тутам унаа, хоолны зардал 93000 төгрөг олгож байна. 100%	/13,392. 000 төгрөг/ Нийт албан хаагчийн жилийн төсөв	

	5	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг	Жилд 1-ээс доошгүй удаа	Албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг оношилгоонд хамруулах зардлыг 2019 оын төсөвт суулгасан. 50%		
			Албан хаагчдын хамрагдалт	100%			
Хэсгийн дундаж: 84%							
Үнэлгээний дундаж хувь: 88.8%							

Албан хаагчдыг чадавхижуулах, мэргэшүүлэх зорилгоор 2018 оны сургалтын төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтийг ханган ажилласан. Байгууллагын хэмжээнд 2018 онд давхардсан тоогоор 13 албан хаагч гадаад улсад, 22 албан хаагч дотоодын сургалт, семинарт оролцож, туршлага судалж, мэдлэгээ дээшлүүлсэн. Үүнд:

Гадаад сургалтаар:

- БНХАУ-ын Гансугийн байгалийн эрчим хүчний судалгааны хүрээлэнгээс зохион байгуулсан “Хөгжиж буй орнуудын нар салхины сэргээгдэх эрчим хүчний сургалт, семинар”-т 1 албан хаагч,
- Тайвань Улсад зохион байгуулсан “Агаарын бохирдлын менежментийн бодлого” сэдэвт санал солилцох семинарт 1 албан хаагч,
- Хятад улсын Гансу аймгийн Ланжоу хотод “Нүүрс, сайжруулсан түлш, зуухны технологи” сэдэвт сургалтанд 4 албан хаагч
- Япон улсын Токио хотод зохион байгуулагдсан “Агаарын бохирдлын менежментийн чадавхийг бэхжүүлэх” сургалтад 1 албан хаагч,
- Япон улсад “Цэвэр хөгжлийн механизм” сэдэвт сургалтад 2 албан хаагч
- Хятад улсын Бээжин хотод “Бээжин, Тянижин, Хэбэй бүс дэх агаарын бохирдлыг сайжруулах” сэдэвт семинарт 1 албан хаагч
- Малайз улсад “Азийн хотуудын агаарын чанарын бүс нутгийн зөвлөлдөх уулзалт”-д 1 албан хаагч
- Хятад улсад “Нүүрстөрөгчийн бага ялгаралтай хотын хөгжил” сэдэвт форумд 2 албан хаагч

тус тус оролцов.

Дотоод сургалтаар:

- Удирдлагын академийн Төрийн удирдлагын менежерийн 1.5 жилийн сургалтад 1 албан хаагч,
- ХБНГУ-ын Байгаль орчны агентлаг болон Цаг уур, орчны шинжилгээний газраас хамтран зохион байгуулсан “УБ хотын цаг уурын болон өгөгдөл солилцох тархалтын загварчлалыг сонгох” сэдэвт сургалтанд 2 албан хаагч,
- Азийн цэвэр агаар байгууллага болон Цаг уур, орчны шинжилгээний газраас хамтран зохион байгуулсан “Агаар бохирдуулагч эх үүсвэрийн бүртгэл, тооллого, ялгарал” сэдэвт сургалт семинарт 7 албан хаагч
- Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын шалтгаан нөхцөл” сэдэвт багц сургалтад 7 албан хаагч,

-
- Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан "Төрийн захиргааны төв байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудын нэгдсэн сургалт"-д 1 албан хаагч,
 - Сангийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зохион байгуулсан Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх АЗ сертификат олгох сургалтад -4 албан хаагч,
 - БОАЖЯ-наас зохион байгуулсан "Агаар бохирдуулагч эх үүсвэрүүдийн бүртгэл тооллого явуулах арга зүй" сургалтад 2 албан хаагчийг тус хамруулсан.

Байгууллагын нийт 17 албан хаагчийн хувийн хэргийг шинэчилж, шинээр ажилд орсон 3 албан хаагчид хувийн хэрэг үүсгэж холбогдох баримтуудыг хавсарган хувийн хэргийн баяжилтыг хийж ажилласан. Албан хаагчдын нэгдсэн судалгааг боловсрол, ажилласан жил, зэрэг зэв, томилгоо, сахилга шийтгэл, сургалтад хамрагдсан байдал, шагнал урамшуулал зэрэг үзүүлэлт тус бүрээр шинэчлэн гаргасан.

2018 онд 4 албан хаагчийн цалингийн шатлалыг албаны даргын шийдвэрээр ахиулсан бөгөөд 3 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл тус тус олгосон байна.

Байгууллагын албан хаагчдын "Ээлжийн амралт эдлүүлэх хуваар"-ийг Газрын даргын 2018 оны А/17 дугаар тушаалаар батлуулж хэрэгжилтийг хангуулан ажилласан. Нийт 14 албан хаагч ээлжийн амралтаа хугацаанд нь биеэр эдэлж, ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй 1 албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх заалтыг үндэслэн 1,5 сарын албан тушаалын цалинтай тэнцэх мөнгөн урамшууллыг олгосон.

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх журам", Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2014 оны 220 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэл, дүүргийн орон нутгийн төсвийн байгууллага, өмчит үйлдвэрийн газрын ажиллагсдад үр дүнгийн шагнал, урамшуулал олгох журам"-ын хүрээнд Газрын даргын дэргэдэх зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хурлаар байгууллагын албан хаагчдын "Үр дүнгийн гэрээ", ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэн, ажиллагсдыг шагнаж урамшуулсан. Байгууллагын 2018 оны жилийн эцсийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээгээр "А" буюу "Маш сайн" үнэлгээтэй 3 албан хаагч, "В" буюу "Сайн" үнэлгээтэй 7 төрийн жинхэнэ албан хаагч дүгнэгдсэн. Мөн хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа 3 албан хаагчийн тайланг дүгнэж, 2018 оны IY дүгээр улиралд шинээр ажилд орсон 3 төрийн жинхэнэ албан хаагчийн тухайн улиралд хийсэн ажлын тайланг сонслоо. Газрын даргын зөвлөлийн хуралдааны шийдвэрээр "А" буюу "Маш сайн", "В" буюу "Сайн" үнэлгээгээр дүгнэгдсэн 10 албан хаагчдад Газрын даргын тушаалаар мөнгөн урамшуулалыг олгосон.

Байгууллагын албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд 1 албан хаагчийн сургалтын зардалд 75000 төгрөг, 3 албан хаагчид 540,000 төгрөгийн мөнгөн тусламж, олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр албан хаагчдын хүүхдүүдэд 441,000 төгрөгийн үнэ бүхий бэлэг, идэвхи зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж төр, нутгийн захиргааны байгууллагын шагналаар шагнагдсан 1 албан хаагчид дагалдах мөнгөн шагнал болох 30,000 төгрөг, өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хүрээнд гэр хороололд амьдардаг 3 ажилтанд 314,900 төгрөгийн түлшний хөнгөлөлт мөнгөн тусламжийг зарцууллаа.

Ажлын амжилт гаргасан, үр бүтээлтэй ажиллаж байгаа албан хаагчдыг төрийн болон салбарын, нутгийн захиргааны шагналд тодорхойлж:

- БОАЖЯ-ны “”Жуух бичиг”-ээр -1
- Нийслэлийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр -3
- НИТХ-ын “Хүндэт өргөмжлөл”-өөр -1
- Нийслэлийн “Шилдэг залуу” медалиар -2
- Нийгмийн ардчилал Монголын эмэгтэйчүүдийн холбооны Шилдэг эмэгтэй удирдагч медаль-1
- Байгууллагын 2018 оны шилдэг ажилтан -1, нийт 9 албан хаагчийг тус тус шагнуулсан.

Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-г шинэчлэн баталсан бөгөөд журамд албан хаагчдын албан томилолт, чөлөө олголт зэрэг хөдөлмөрийн харилцаа, цаг ашиглалтыг нарийвчлан зохицуулсан.

ЗГ-ын Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" 2018 оны 258 дугаар тогтоол, НЗД-ын "Сахилга, хариуцлага, дэг журмыг сайжруулах тухай" 2017 оны 02 дугаар албан даалгаварыг байгууллагын албан хаагчдад танилцуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Газрын даргын 2018 оны А/52 дугаар тушаалаар байгууллагын Ёс зүйн хороог шинэчлэн байгуулсан. Мөн байгууллагын хэмжээнд мөрдөх "Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг шинэчлэн баталж албан хаагчдын ажлын цагийг автомат цаг бүртгэлийн системээр бүртгэн хяналт тавьж, хоцорсон тасалсан цагийг цалингийн тооцоотой уялдуулан тооцох механизмыг бүрдүүллээ. Төрийн захиргааны албан хаагчийн “Ёс зүйн дүрэм”-ийг нийт албан хаагчдад танилцуулан мөрдөн ажиллаж байгаа бөгөөд ажлын байрыг дур мэдэн орхин удаан хугацаагаар ажил тасалсан Дотоод болон шуурхай ажил хариуцсан мэргэжилтэн Т.Гэрэлмааг ажлаас чөлөөлж, хөдөлмөрийн гэрээг цуцалсан.

Албан хаагчдын ажлын цагийг автомат цаг бүртгэлийн ситемээр бүртгэн хяналт тавьж, хоцорсон тасалсан цагийг цалингийн тооцоотой уялдуулан тооцож байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт:

Тайлант хугацаанд байгууллагын хэмжээнд нийт 84 өргөдөл, гомдол ирсэнээс хугацаандаа шийдвэрлэж хариу өгсөн 82, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 2 өргөдөл, гомдол байна.

Хүснэгт 11.

Нэгж/хэлтэс	Хугацаандаа шийдвэрлэсэн	Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн	Шийдвэрлэх хугацаандаа байгаа	Нийт
Удирдлага	-	-	-	-
Захиргаа удирдлагын хэлтэс	16	-	-	16
Бодлого зохицуулалтын хэлтэс	42	2	-	44
Агаарын чанарын хяналтын хэлтэс	24	-	-	24
Нийт	82	2	-	84

2018 оны жилийн эцсийн байдлаар 84 өргөдөл, гомдол ирсэн бөгөөд шийдвэрлэлийн дундаж хугацаа 14 хоног 1 цаг, 43 минут байгаа нь 2017 оны өргөдөл, гомдлын

шийдвэрлэлтийн дундаж хугацаатай харьцуулахад 1 хоног 6 цагаар багассан үзүүлэлттэй байна.

Байгууллагад цаасаар ирсэн өргөдөл гомдлыг скайнердаж www.smartcity.mn-д оруулан байгууллагын удирдлагад шилжүүлэн ажиллаж байна.

Албаны албан хаагчдаас ирсэн өргөдөл гомдлыг бүртгэн удирдлагад тухай бүрт нь танилцуулан хүний нөөц, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэнд шилжүүлэн ажиллаж байна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар:

Албан бичиг хөтлөлт: Газрын хэмжээнд 2018 оны 12 сарын 24–ны байдлаар нийт 1104 албан бичиг ирсэнээс хариутай бичиг 412, хариугүй 692 албан бичиг бүртгэгдсэнийг тухай бүр шийдвэрлэж ажилласан байна. Нийт ирсэн албан бичгийн шийдвэрлэлтийн байдлыг авч үзвэл хугацаандаа шийдвэрлэсэн - 1028, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн -60, шийдвэрлэх шатандаа байгаа - 16 албан бичиг байна. Хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь 94.79 хувьтай байна. Хүснэгт -1.

Хүснэгт -12. Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газарт 2018 онд ирсэн албан бичгийн шийдвэрлэлтийн мэдээ

№	Нэгж	Нийт	Хариугүй	Хариутай	Хугацаандаа шийдвэрлэсэн	Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн	Тооцогдсон зөрчлийн тоо	Шийдвэрлэлтийн%
1	Агаарын чанарын хяналтын хэлтэс	344	221	123	340	13	86	95.0%
2	Бодлого зохицуулалтын хэлтэс	335	231	104	332	18	100	92.18%
3	Захиргааны хэлтэс	421	237	184	415	29	26	91.82%
4	Удирдлага	4	3	1			6	100%
	Нийт	1104	692	412	1087	60	218	94.75%

Тус газраас холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд 654 албан бичиг явуулсан ба албан бичгийн бүрдүүлэлт, стандартыг мөрдөж, хяналт тавин ажиллаж байна.

Албан хэрэг хөтлөлтийн Edoc.ub.gov.mn, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн smartcity.mn програмуудын шинэчлэлт болон хэрэглэх заавар зөвлөмжийг нийт албан хаагчдад танилцуулан ажиллалаа.

Архив бүрдүүлэлт, хадгалалт ашиглалт: Байгууллагын 2009-2016 оны архивын баримт бичигт нөхөн бүрдүүлэлтийн ажлыг хийн Нийслэлийн Архивын газрын дэргэдэх ББНШАЗК-ын 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 01 дүгээр хурлаар хэлэлцэгдэж 2009-2012 оны байнга хадгалах 121 хадгаламжийн нэгжээр 1 дүгээр хөмрөг, 2013-2016 оны

байнга хадгалах 130 хадгаламжийн нэгжээр 2 дугаар хөмрөг, түр хадгалах 2009-2016 оны 473 хадгаламжийн нэгж, 70 жил хадгалах 25 хадгаламжийн нэгж, цахим баримтын 8 хадгаламжийн нэгжээр нөхөн бүрдүүлэлт хийн батлуулж, 2009-2012 оны 1 дүгээр хөмрөгийг НАГ-ын актын дагуу хүлээлгэн өглөө. Мөн эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны ач холбогдолгүй, хадгалах хугацаа дууссан гэж үзсэн 10 хэргийн 146 хадгаламжийн нэгжийг байгууллагын архивын ажлын үндсэн заавар, журмын дагуу устгах ажлыг газрын даргын 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/19 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулан зааврын дагуу зохион байгуулж гүйцэтгэсэн. Хүчингүй болгосон 2014 оны 1, 2015 оны 1, 2016 оны 1, 2017 оны 1, нийт 4 захирамжлалын баримт бичигт кодификаци хийсэн.

2015 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2017 оны 115 архивын баримтыг хуваарийн дагуу нэгж хэлтсээс хүлээн авсан.

2018 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулан Нийслэлийн Архивын газрын 05 дугаар сарын 25-ны өдрийн хурлаар хэлэлцэн батлуулав.

Тус байгууллагын архивт нийт 743 цаасан суурьт баримт хадгалагдаж байгаагаас

- Байнга хадгалах 167
- Түр хадгалах 546
- 70 жил хадгалах 30
- Тусгай төрлийн баримт буюу дүрс бичлэгийн 14, гэрэл зургийн 1 баримт хадгалагдаж байна.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан хаагчдад архивын баримтыг ашиглуулах, мэдээ, лавлагаа гарган үйлчилж байна.

Хууль эрх зүйн чиглэлээр:

ЗГ-ын Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" 2018 оны 258 дугаар тогтоол, НЗД-ын "Сахилга, хариуцлага, дэг журмыг сайжруулах тухай" 2017 оны 02 дугаар албан даалгаварыг байгууллагын албан хаагчдад танилцуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Тус газартай бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэхээр гэрээ байгуулсан ч гэрээний үүргээ биелүүлээгүй 4 аж ахуйн нэгж, байгууллагыг шүүх, хуулийн байгууллагад өгч нэхэмжлэл гаргасан. Шүүхээс Номгон хайрхан ХХК-д хамаарах нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, Тара ХХК, Хүрд ХХК, "Ворм энерги" ХХК-иудад хамаарах нэхэмжлэх шүүхэд шийдвэрлэх шатандаа явж байна. /Хүснэгт-2-т харуулав./

Хүснэгт 13. Шүүх, хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэхээр нэхэмжлэл гаргасан талаарх мэдээлэл

д/д	Нэхэмжлэгч	Хариуцагч	Нэхэмжлэлийн агуулга	Шүүхийн шийдвэр	Тайлбар
1	Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газар	"Тара" ХХК	Түлш нийлүүлэх гэрээний үүрэг зөрчсөн тул алдангийн хамт 214,555,625 төгрөг гаргуулахаар нэхэмжилсэн.	Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018.03.05-ны өдрийн 621 дүгээр магадлалаар хариуцагч "Тара" ХХК-иас 168,244.500 төгрөг	Хариуцагчаас Улсын Дээд шүүхэд хяналтын журмаар гомдол гаргасан

				гаргуулж, нэхэмжлэгчид олгохоор шийдвэрлэсэн.	хурал зарлагдаагүй байна.
2	Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газар	“Хүрд” ХК	Усан халаалттай зуух нийлүүлж, суурилуулах гэрээний үүрэг зөрчсөн тул дутуу суурилуулсан 30 зуухны үнэ 16,643.880 төгрөг гаргуулахаар нэхэмжилсэн.	Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх 2018.03.12-нд хуралдаж нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон.	Шүүхийн шийдвэрийг гардаж аваагүй байна.
3	Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газар	“Ворм энерги” ХХК	Түлш нийлүүлэх гэрээний үүрэг зөрчсөн тул алдангийн хамт 171,230.561 төгрөг нэхэмжилсэн.	Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018.06.06-ны өдрийн магадлалаар харицагч “Ворм энерги” ХХК-иас 136,984,449 төгрөг гаргуулж, нэхэмжлэгчид олгохоор шийдвэрлэсэн.	Хариуцагчаас Улсын дээд шүүхэд хяналтын журмаар гомдол гаргах хугацаа дуусаагүй байна.
4	Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газар	Номгон хайрхан ХХК	Халаалт болон ахуйн хэрэглээний хосолмол цахилгаан зуух нийлүүлж, суурилуулах гэрээний үүрэг зөрчсөн тул 23,925.000 төгрөг нэхэмжилсэн.	Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд 2018.05.09-нд нэхэмжлэл гаргасан.	Хурал зарлагдаагүй байна.

Худалдан авах ажиллагааны чиглэлээр:

“Бараа, ажил, үйлчилгээ 2018 онд худалдан авах ерөнхий төлөвлөгөө”-г боловсруулан газрын даргаар батлуулан www.shilendans.gov.mn -д байршуулж олон нийтэд ил тод зарлан мэдээлсэн.

Тус газарт Нийслэлийн Засаг даргаас эрх шилжүүлсэн болон байгууллагын урсгал зардалд төсөвлөгдсөн бараа, ажил үйлчилгээний худалдан авах ажиллагааг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn -ээр хялбаршуулсан цахим хэлбэрээр зохион байгуулж, тендэртэй холбоотой бүх төрлийн баримт бичгийг /файлаар/ нийтэлж, ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллалаа.

176,000.0 мянган төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 2 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг зохион байгуулж худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д тендерийн урилга, зар, тендерийн холбогдолтой баримт бичиг болон сонгон шалгаруулалтын дүнг мэдээллэн цахимаар сонгон шалгаруулалтыг явуулсан.

Төсөв санхүү, орлого бүрдүүлэлтийн чиглэлээр:

Байгууллагын төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн ханын самбарт байршуулж төсвийн ил тод байдлыг ханган ажиллалаа.

2018 оны 12 дугаар сарын 18-ны байдлаар 808,769,700.0 (найман зуун найман сая долоон зуун жаран есөн мянга долоон зуун)төгрөгийн урсгал санхүүжилт авч, Агаар орчин болон агаар бохирдуулагч эх үүсвэрт хийсэн хэмжилтийн орлого 17,670,000.0 (арван долоон сая зургаан зуун далан мянган) төгрөгийн орлого оруулсан байна. Орлогын төлөвлөгөөг 176.7 хувиар давуулж биелүүлсэн. Нийт 582,305,368.0 (таван зуун наян хоёр сая гурван зуун таван мянга гурван зуун жаран найман)төгрөгийг зарцуулсан.

Байгууллагын 2019 оны төсвийн саналыг боловсруулан НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.

“Нийслэлийн хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан”-д гаргасан тайлан мэдээ:

Тус газрын үйл ажиллагааны чиг үүрэгтэй хамаарал бүхий 8 тогтоол, 21 захирамж, үүрэг даалгаврын 62 заалтыг хяналтанд авч хэрэгжилтийг **Нийслэлийн хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан** monitoring.ub.gov.mn –д болон албан бичиг, цахим хаягаар тайлагнаж ажиллав.

- 1.Улсын Их Хурлын 1 тогтоолын 1 заалтын хэрэгжилт 100%
2. Улсын Их Хурлын Байнгын хорооны 1 тогтоолын 8 заалтын хэрэгжилт 92,5%
3. МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигийн 2 заалтын хэрэгжилт 100%
4. МУ-ын Засгийн газрын 5 тогтоолын 25 заалтын хэрэгжилт 93%
5. Засгийн газрын 6 хуралдааны тэмдэглэлийн 10 заалтын хэрэгжилт 70%
6. Засгийн газрын 1 албан даалгаврын 11 заалтын хэрэгжилт 100%
7. МУ-ын Ерөнхий сайдын 1 захирамжийн 1 заалтын хэрэгжилт 100%
8. НИТХ-ын 4 тогтоолын 6 заалтын хэрэгжилт 95%
9. Нийслэлийн Засаг даргын 4 захирамжийн 4 заалтын хэрэгжилт 100%
10. Нийслэлийн Удирдлагуудаас өгсөн 8 үүрэг даалгаврын 10 заалтын хэрэгжилт 93%

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

Үйл ажиллагааны ил тод байдал:

Байгууллагын www.aprd.ub.gov.mn цахим хуудсанд байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, үйл ажиллагааны чиглэл, бүтэц зохион байгуулалтын схем, тус байгууллагаас үзүүлдэг үйлчилгээний тухай мэдээлэл, бүрдүүлэх бичиг баримтын жагсаалт, үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, газрын даргын тушаалыг тухай бүр байршуулж ажиллаж байна.

2018 онд тус байгууллага нь хүний нөөцийн чиглэлээр 67, үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 57, нийт 127 захирамжлалын баримт бичиг гарган үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилласан байна.

Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмыг хэрэгжүүлэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд байгууллагын шилэн дансны мэдээллийг цаг тухайд нь хагас, бүтэн жилээр, улирал, сар, тухай бүр гэсэн хугацаагаар ангилж, хавсралтын дагуу мэдээллэн ажиллаж байна. Мөн 2018 оны төсвийн гүйцэтгэлийн жилийн болон сар бүрийн мэдээг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт цаг тухай бүр байршуулж, төсвийн ил тод байдлыг ханган ажилласан. Байгууллагын шилэн дансанд нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8,9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл, байгууллагын батлагдсан орон тоонд гарсан өөрчлөлтүүд, хөрөнгө мөнгө зарцуулах, өр авлага үүссэн шийдвэр болон бусад холбогдох мэдээ тайланг байршуулж мэдээллэн ажиллаж байна.

Агаар бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тооллого явуулах журмын төсөлд олон нийтийн санал авахаар 2018 оны 01-р сарын 10-нд байгууллагын цахим хуудсанд байрлуулан санал авсан. <http://aprd.ub.gov.mn/khuuli-erkh-zui/saidin-bolon-nzdin-zakhiramjalin-barimt-bichig.html>

НИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол 2017.06.07-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор баталсан Нийслэлийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журмын хүрээнд UBlegal.mn цахим хуудсанд 2014 оны “А” тушаал 19-ийг, 2015 оны “А” тушаал 29-ийг, болон 2016 оны “А” тушаал 22-ийг, “Б” тушаал 50-ийг, 2017 оны “А” тушаал 49-ийг, “Б” тушаал 42-ийг, 2018 оны “А” тушаал 67-ийг, “Б” тушаал 57-ийг тус тус бүртгэсэн.

Нийслэлийн агаарын чанарын суурин харуулын мэдээг цаг тухайд нь онлайнаар www.agaar.mn, www.aprd.ub.gov.mn, www.aqicn.org сайтуудаар, суурин харуулын байршил бүрд болон БОАЖЯ, нийслэлийн нутгийн захиргааны байр Хангарди ордон, УЦУОШГ-т байрлах дэлгэцүүдээр, мөн гар утасны “Агаар” аппликейшнээр иргэд, олон нийтэд мэдээллийг хүргэн ажиллаж байна.

Хүний нөөцийн ил тод байдал: Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, Ажлын байранд мөрдөх дэглэм, Хүний нөөцийн хөгжил хөтөлбөр зэргийг <http://new.aprd.ub.gov.mn> цахим хуудсанд байршуулж мэдээллийн самбараар мэдээллэж ажиллалаа.

Хувийн ашиг сонирхолын болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах 7 албан тушаалтны мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулан www.meduuleg.iaac.mn мэдүүлгийн цахим системд оруулж баталгаажуулалтыг хийж ХАСХОМ-1, ХАСХОМ-2 тайланг хуулийн дагуу тайлагнасан.

www.shilendans.gov.mn-д сар бүр оруулах мэдээлэлд албаны бүтэц орон тоотой холбоотой мэдээллийг, тухай бүр оруулах мэдээлэлд худалдан авах, хөрөнгө мөнгө зарцуулах ажиллагаатай холбоотой мэдээллийг тус тус тогтмол оруулж, баталгаажуулж байна.

ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТ

Хүснэгт 14. Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт

№	Шалгуур үзүүлэлт		Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал			
1	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Байгууллагын үйл ажиллагааны стратегийн үндсэн зорилго, зорилтуудыг цахим (http://aprd.ub.gov.mn/c/22) хуудас болон мэдээлийн самбарт байрлуулж тухай бүр шинэчлэн ажиллаж байна.	100
2	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Иргэдийг хүлээн авах цагийн хуваарийг батлуулан мэдээллийн самбартаа байрлуулан, өргөдөл гомдлыг ажлын өдрүүдэд 09.00-18.00 цагийн хооронд дотоод болон шуурхай ажил хариуцсан мэргэжилтэн байнга хүлээн авч ажиллаж байна.	100
3	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Үндсэн 3 үйлчилгээ үзүүлж байна. Үүнд: 1. Зуух болон түлшний хаягдал утааны хийн хэмжилт хийх 2. Орчны агаарт хэмжилт хийх 3. Авто тээврийн хэрэгслийн хаягдал утааны хийн хэмжилт хийх Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтыг байгууллагын цахим хуудас (http://new.aprd.ub.gov.mn/c/8/3) ба мэдээлийн самбарт байршуулан ажиллаж байна.	100
4	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Үйл ажиллагаанд мөрдөж байгаа эрх зүйн баримтыг дараах байдлаар http://aprd.ub.gov.mn/k?mlD=27 , http://aprd.ub.gov.mn/c/8/3 цахим болон байгууллагын мэдээллийн самбарт тухай бүр шинэчлэн байрлуулан ажиллаж байна.	100

5	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;	Агаар бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тооллого явуулах журмын төсөлд олон нийтийн санал авахаар 2018 оны 01-р сарын 10-нд байгууллагын цахим хуудсанд байрлуулан санал авсан. http://aprd.ub.gov.mn/khuuli-erkh-zui/saidin-bolon-nzdin-zakhiramjalin-barimt-bichig.html	100
6	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	НАББГ-аас орчны агаарт хэмжилт хийх, зуух болон түлшний хаягдал утаа, автотээврийн хэрэгсэлийн хаягдал утаанд хэмжилт хийж агаар бохирдуулагч бодисын хэмжээг тодорхойлох үйлчилгээ үзүүлдэг бөгөөд төрийн үйлчилгээг хурдан шуурхай, тасралтгүй үзүүлэх зорилгоор ШУТИС-Дулаан техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнтэй холбогдох хууль журмыг үндэслэн гэрээ байгуулж Усан халаалтын зуухны хаягдал утааны хэмжилтийн ажлыг 2017-2018 оны халаалтын улиралд буюу 2018 оны 05 дугаар сарын 15-ыг хүртэл хугацаанд тус байгууллагаар гүйцэтгүүлсэн. Гэрээт ажлын хугацаанд нийт 9 удаагийн хэмжилтийг дээрх байгууллага хийсэн.	100
7	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;	“Утааны эсрэг ээж аавууд” төрийн бус байгууллагын агаарын бохирдлын эсрэг авч хэрэгжүүлж буй ажлыг байгууллагын дотоод мэдээллийн самбарт мэдээлэн ажиллаж байна.	100
8	Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	-	

9	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх;	Монгол Улсын Засгийн газар болон Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай хийсэн санамж бичгийн дагуу Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах хяналтын чадавхыг бэхжүүлэх төслийн 3 дугаар үе шат хэрэгжихээр 2018 оны 12 дугаар сарын 10-нд нээлтийн семинараа хийсэн. Төслийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг цахим хуудсанд тухай бүр байрлуулан олон нийтэд мэдээлэн ажиллаж байна.	100
Хэсгийн дундаж хувь: 100%			
Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал;			
1	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;	2018 онд төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоо гараагүй.	100
2	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, Ажлын байранд мөрдөх дэглэмийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан. (http://new.aprd.ub.gov.mn/k/11?mID=33)	100
3	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Хүний нөөцийн хөгжил хөтөлбөрийг цахим хуудсанд байршуулсан. (http://new.aprd.ub.gov.mn/c/11/13)	100
4	Хүний нөөцийн удирдлалгын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	Байгууллагын танилцуулга, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, Даргын тушаал, ажлын байрны тодорхойлолт зэргийг цахим хуудсанд байршуулж мэдээлсэн.	100
5	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журмыг цахим хуудсанд байршуулсан. (http://new.aprd.ub.gov.mn/c/11/13)	100
Хэсгийн дундаж хувь: 100			
Хэрэгжилтийн дундаж хувь: 100			

ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД МЭДЭЭЛЭЛ

Холбогдох чиг үүргийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагуудтай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр хамтран ажилласан тухай

- Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай хамтран хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхийг бэхжүүлэх” төслийн 3 дугаар үе шат 2018 оны 12 дугаар сард эхэлж байгаатай холбогдуулан төслийн нээлтийн семинар болон олон улсын хандивлагч байгууллагуудтай хийх уулзалтыг зохион байгуулж ажиллалаа.

- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Байгаль орчин, ногоон хөгжлийн хороотой хамтран “Агаарын бохирдлын эсрэг хүчээ нэгтгэе” сэдэвт хэлэлцүүлгийг 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо, Нийслэлийн Тээврийн газар, Цаг Уур орчны шинжилгээний газар, Шинжлэх Ухаан технологийн их сургууль, Монгол Улсын их сургууль, Хөдөө Аж ахуйн их сургууль, Эрүүл мэндийн үндэсний төв, Монголын Ногоон санхүүгийн корпораци, зэрэг байгууллагууд оролцож, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр баримталж буй бодлого, агаарын чанарын хяналт шинжилгээ, агаарын бохирдлоос эрүүл мэндээ хамгаалах чиглэлээр эрүүл мэндийн салбараас хэрэгжүүлж буй арга хэмжээ, гэр хорооллын агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний зардлын үр ашгийн үнэлгээний судалгаа зэргийг хэлэлцсэн. Хэлэлцүүлгээс холбогдох байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, мэдээллийн сан үүсгэх, боловсон хүчний чадавхийг нэмэгдүүлэх, иргэд рүү чиглэсэн сургалт сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах саналууд гарсан.


- “Утааны эсрэг ээж аавууд” ТББ-тай хамтран ажиллах гэрээ байгуулан СХД-ийн 8 дугаар хорооны нийт 60 жирэмсэн эхчүүдийг хамруулан сургалт явуулж агаарын бохирдлоос эрүүл мэндээ хамгаалах талаар заавар зөвлөгөө өгч ажилласан.

- Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны 53 дугаар тэмдэглэл, Засгын газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2018 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн А/159 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/462 дугаар захирамжаар Налайх дүүргийн иргэдийн дунд нүүрсний уурхайн үйл ажиллагаатай холбогдуулан зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн дагуу 2018 оны 06 дугаар сарын 16-ны өдөр зөвлөлдөх уулзалтыг НЗДТГ, НБОГ болон холбогдох байгууллагуудтай хамтран хэлэлцүүлэг зохион байгуулсан. Энэхүү зөвлөлдөх уулзалтад манай байгууллагаас Налайх дүүрэгт хууль бусаар нүүрс олборлуулахгүй тохиолдолд Налайх болон Улаанбаатар хотын иргэдийн нүүрсний хэрэглээ, ханган нийлүүлэх тогтолцоог бүрдүүлэх сэдэвтэй илтгэл тавьж, зохион байгуулагчаар ажилласан.



Зураг 18. Налайх дүүргийн иргэдтэй хийсэн зөвлөлдөх уулзалт.

• Улаанбаатар хотын ерөнхий менежерийн тушаалаар зохион байгуулагдсан “Өгөөмөр өдөр” өдөрлөгийн хүрээнд хуучин эд зүйлсээ солилцох, үнэгүй өгөх арга хэмжээнд байгууллагаараа идэвхитэй оролцон тодорхой эд зүйлсийг Чингэлтэй дүүргийн Тохижолт, нийтийн аж ахуйн хэлтэст хүлээлгэн өгч ажилласан.



Зураг 19. “Өгөөмөр өдөр” арга хэмжээнд НАББГ-аас хандивласан зүйлс

Ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих, хөдөлмөрийн явцад бий болсон алжаал ядаргааг тайлах, ажлын чадварыг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор албан хаагчдад ажлын байранд хийх дасгал хөдөлгөөнийг зааж, сурган ажиллагсдын эрүүл мэндэд анхааран ажиллаж байна.

2018 оны 5 сарын 19-нд зохион байгуулагдсан “Улаанбаатар Марафон” олон улсын гүйлтэд нийт 6 албан хаагчийг хамруулан байгууллагаараа идэвхтэй оролцсон.

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу зохион байгуулсан үйл ажиллагааны талаар:

Хүснэгт 15.

№	Иргэд, аж ахуйн нэгж байгууллага	Хүсэлт, өргөдлийн товч утга	Шийдвэрлэсэн байдал
A	Орчны хэмжилт болон халаалтын зуух, түлшний хэмжилтийн талаар		
1	“Тэмүүжин анд” Цэцэрлэг	Агаар цэвэршүүлэгч хүсэх тухай	“Улаанбаатар Цэвэр Агаар” төслөөс 8 ширхэг агаар цэвэршүүлэгч хүлээлгэн өгсөн.

2	“Говь Түшээ” ХХК	Зуухны хэмжилт хийлгэх тухай	2018 оны 03 дугаар сарын 27-ний өдөр хэмжилтийн ажлыг хийж 2018.03.28/010 тоот албан бичгээр хариу хүргүүлсэн.
3	“Сэлх Вилла” ХХК	Зуухны хэмжилт хийлгэх тухай	Шинжлэх ухаан технологийн их сургууль, дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнд 2018 оны 03 дугаар сарын 9-ний өдөр 03/155 дугаартай албан бичгээр хэмжилт хийлгүүлэх хүсэлтийг гарган, гүйцэтгүүлсэн.
4	“Примо Ази” ХХК	Зуухны хэмжилт хийлгэх тухай	Шинжлэх ухаан технологийн их сургууль, дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнд 2018 оны 03 дугаар сарын 9-ний өдөр 03/155 дугаартай албан бичгээр уламжлан, хэмжилтийн ажлыг гүйцэтгүүлсэн.
5	“Ану сервис” ХХК	Зуухны хэмжилт хийлгэх тухай	2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр хэмжилт хийж, дүн гарган өгсөн.
Б Автотээврийн хэрэгслээс ялгарах бохирдлыг бууруулах талаар			
1	“Любрикон Монголиа” ХХК	Авто машины утаа хэмжүүлэх тухай	Монгол Улсын нутаг дэвсгэрт Евро стандартын шатахууны хэрэглээг нэвтрүүлэх зорилгоор бензин, дизелийн түлшний стандартууд 2017 онд шинэчлэн батлагдсан бөгөөд чанар сайжруулагч аливаа нэмэлт нэмж, хольж болохгүй, LUBRICON A-112M түлшний нэмэлт бүтээгдэхүүний туршилтын ажлыг хийх боломжгүй талаар 2018 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн 03/201 дугаартай албан бичгээр хариу хүргүүлээ.
2	“Хөх Монгол Констракшн” ХХК	Агаарын бохирдол шүүх Эко зогсоол төслийн тухай	“Хөх Монгол Констракшн” ХХК “Эко зогсоол” төслийн саналтай танилцаж, эко зогсоолын агаар цэвэршүүлэгчийн үйл ажиллагаатай холбогдон гарах зардал, мөн түүний хүчин чадал, үр ашиг зэргийг нарийвчлан тодорхой болгох талаар зөвлөмж өгч төслийн хүрээнд туршилтын зориулалтаар 1 эко зогсоол байгуулахаар төлөвлөн ажиллаж байгаатай холбогдуулан түүний агаар цэвэршүүлэгч төхөөрөмжийн үр дүнд хэмжилт хийж, нөлөөллийг тодорхойлох бололцоотой болохыг мэдэгдсэн тухай Нийслэлийн Засаг дарын Ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогчийн 2018 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 02-302/1718 дугаартай албан бичгээр хариу хүргүүлээ.
3	“Тэмүүжин” ХХК	Автомашин хэмжилт хийлгэх, хамтран ажиллах тухай	Тус компаниас санал болнож буй дизель хөдөлгүүрийн тортогжилт шүүх төхөөрөмжийн материалтай танилцаад, нийтийн тээврийн автобусанд суурилуулан зохих дүрэм, журмын хүрээнд туршилт хийж, хамтран ажиллахад татгалзах зүйлгүй болох тухай 2018 оны 06 дугаар сарын 22 -нд 03/371 дугаар албан бичгээр хариу хүргүүлээ.
4	“Экологбус” ХХК	Стандартын төсөл танилцуулж, санал авах тухай.	Стандартын төсөлтэй танилцан тортогжилт шүүх зориулалттай (DPF) тухайн төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны гарын авлага мэт ойлгогдож байсан тул тусгайлан стандарт батлуулах шаардлаггүй талаар 2018 оны 06 дугаар сарын 15 -ний өдөр 03/352 дугаартай албан бичгээр хариу хүргүүлээ.
5	“Эс Би Эл” ХХК	Шатахуун зарцуулалт хэмнэх, утаа бууруулах төхөөрөмж “ННО”	Хэмжилтийн дүнг доор буюу жич хэсэгт тайлбарыг гаргалаа.

		генератор буюу “Допинг” систем	
6	“Ай Эс Өү Өү”	утаа бууруулах “BLADE” шүүлтүүр, төхөөрөмж	Хэмжилтийн дүнг доор буюу жич хэсэгт тайлбарыг гаргалаа.
3	Суурин харуул болон мэдээлэл технологийн талаар		
1	Иргэн Г.Орхон-Туул	Суурин харуулын мэдээллийн тухай	2018 оны 1 дүгээр сарын 31-ээс www.agaar.mn , www.air.ub.gov.mn цахим хуудасын мэдээлэл шууд дамжуулах үүрэгтэй сервэр доголдож 2 дугаар сарын 4-ны 14 цагаас хойш тасарсан. Энэхүү сүлжээний доголдолыг шуурхай арга хэмжээ аван зассан бөгөөд 2018 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 9 цагаас эхлэн хэвийн ажиллаж байна.
2	Иргэн Д.Ишдорж	Утаа болон үнэрийн асуудлыг шийдэх салхин сэнсний санал	Тухайн иргэн Орхон аймагт амьдардаг тул Улаанбаатар хотод ирж уулзах боломжгүй бөгөөд нийслэл хотын агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд салхин сэнс суурилуулан агаарын бохирдлыг багасгах талаар төслийн ажлаа танилцуулан мөн манай байгууллагаас мэдээлэл өгч хамтран ажилласан.
3	Иргэн Довчинням	Улаанбаатар хотын агаарын чанарын индексийг хянах аппликейшны талаарх санал	Тухайн иргэний хүсэлт гаргасан агаарын бохирдлыг хэмжих суурин харуулууд Цаг уур орчны шинжилгээний газрын харьяанд байдаг бөгөөд манай зүгээс саналыг тухайн байгууллагад дамжуулан мэдээллэхээр болж Агаар.mn сайтын талаар холбогдох мэдээллийг өгч ажилласан.
4	Иргэн Мөнх-Оргил	Агаарын чанар хэмжигч суурин харуул нэмэх талаар	Нийслэл 11 автомат суурин харуулаар хэмжилт хийж байгаа талаар мэдээлэл өгч, одоо байгаа суурин харуулуудын тоо стандарт нормын дагуу байгааг танилцуулсан.
5	Иргэн Энхтуул	www.agaar.mn сайтын ажиллахгүй байгаа талаар санал хүсэлт	www.agaar.mn сайтын талаар мэдээлэл өгч ажилласан.
6	Иргэн Энэрэл	100 айлд байрлах агаарын чанарын харуул ажиллахгүй байгаа тухай	Тус мэдээллийн самбарууд нь Цаг уур орчны шинжилгээний газрын харьяанд байдаг бөгөөд одоогоор хэвийн ажиллаж байгаа талаар холбогдох мэдээллийг өгч ажилласан.
7	Иргэн Д.Наранцэцэг	7 буудлын орчим агаарын бохирдлыг бууруулах талаар арга хэмжээ авч өгөх	Тухайн иргэнтэй холбогдон мэдээлэл өгч ажиллах гэсэн боловч тухайн иргэнтэй холбогдож чадаагүй.

8	“Грийнлэнд энтерпрайзес” ХХК	“Smog tower” болон орчны агаар цэвэршүүлэх төхөөрөмжүүд ийн танилцуулга	Эдгээр төслүүдийг хэрэгжүүлснээр агаарын бохирдлыг бууруулахад нөлөөлөх нөлөөллийн үр дүнг тодорхойлоход хэмжилт хийн хамтран ажиллах боломжтойг 2018 оны 05 дугаар сарын 25-нд 18/13 тоотор хариу хүргүүлсэн.
4	Агаарын бохирдлыг бууруулах талаар		
1	Иргэн Б. Бямбасүрэн	Оюуны өмчийг хамгаалах, төрийн байгууллагын уялдааг сайжруулах өргөдөл	Оюуны өмчийг хамгаалах, төрийн байгууллагын уялдааг сайжруулах талаар төрийн байгууллагуудтай хамтран ажиллах, талаар уулзаж мэдээлэл өгч ажиллалаа.

Жич: Автотээврийн хэрэгслийн “Туулсан зам, шатахууны шаталтад зарцуулагдаж буй агаар, гадна орчны температур” зэргийг уялдуулан тооцоолж, ялгарч байгаа бохирдлыг хурднаас хамаарсан /NOx болон PM/ хэмжээг “Horiba Mexa720 - Nox-азотын исэл A/F”, “Horiba Mexa600S - PM тортогжилт” хэмжигч Япон улсын багаж ашиглан хэмжилтийн ажлыг 2 төрлийн бүтээгдэхүүн дээр хийж гүйцэтгэсэн.

Нэгдүгээрт. Шатахуун зарцуулалт хэмнэх, утаа бууруулах төхөөрөмж “ННО” генератор буюу “Допинг” систем. “ННО” генератор буюу “Допинг” системийн төхөөрөмжийг суурилуулсан Старекс авто машины NOx- буюу азотын исэл 20км цагийн хурдтай үед 7%, 40км цагийн хурдтай үед 4%, 60км цагийн хурдтай үед 14% бага буюу дунджаар **8.5 %**-иар буурсан байв.

График 6. NOx- буюу азотын исэл гр/км





График 7. PM-буюу тортогжилт гр/км



Хоёрдугаарт. Утаа бүүруулах “**BLADE**” шүүлтүүр, төхөөрөмж. “BLADE” шүүлтүүр, төхөөрөмжийг суурилуулсан Старекс авто машины PM- буюу тортогжилт 20км цагийн хурдтай үед **89%**-иар өссөн, 40км цагийн хурдтай үед **64%**-иар өссөн, 60км цагийн хурдтай үед **53%**-иар өссөн ба энгийн үеийнхээс дунджаар **68.7%**-иар ихэссэн байна. Зам, тээврийн хөгжлийн яаманд 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 03/537 дугаартай албан бичгээр хэмжилтийн дүнг хүргүүлсэн.

График 8. NOx- буюу азотын исэл гр/км





График 9. PM-буюу тортогжилт гр/км



Дотоод хяналт шинжилгээ, үнэлгээний чиглэлээр:

Дотоод үйл ажиллагааны хүрээнд дотоод хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх, удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж байна. Дээд газраас ирүүлсэн тогтоол, шийдвэрийн 94 заалтад хяналт үнэлгээ, шинжилгээ хийн, даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж биелэлтийн мэдээг тайлан, хурлын тэмдэглэлийн хамт НЗДТГ-т хүргүүлсэн.

Засгийн газрын 89-р тогтоол, НЗД-ын А/335 дугаар захирамж болон бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал, тайлагнах хугацааг байгууллагын албан хаагчдад танилцуулсан.

Байгууллагын эд хөрөнгийн ашиглалт хамгаалалтын чиглэлээр:

Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2018 оны ажлын төлөвлөгөө гарган газрын даргаар батлуулан ажилласан. Байгууллагад шинээр худалдан авах, данснаас хасах, балансаас балансад шилжүүлэх, ашиглалтын хугацаа дууссан болон эвдэрч гэмтсэн хөрөнгийг актлахад тухай бүр ӨХБЗ-ийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэн ажиллалаа. Өмч хамгаалах байнгын зөвлөл 2018 онд 12 удаа хуралдаж, тус зөвлөлийн шийдвэрээр ажиллагсдад албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай компьютер -3, хэвлэгч төхөөрөмж -2, хурлын болон албан хаагчдын хэрэгцээнд сандал -26, цаг бүртгэлийн систем, албаны өрөө тасалгаанд камержуулалтын систем зэрэг эд хөрөнгийг худалдан авч ажилтнуудын ажиллах нөхцлийг бүрдүүлсэн.

Газрын даргын тушаалаар Эд хөрөнгийн тооллого хийх комиссыг байгуулж 2018 оны эхний хагас жилд болон жилийн эцсээр тооллогыг тус тус зохион байгуулж нийт 323 нэр төрлийн 5229 ширхэг 312,109,776.0 төгрөгийн хангамжийн хөрөнгө, 301 нэр төрлийн 462 ширхэг 3,548,345,964.0 төгрөгийн үндсэн хөрөнгийг тоолж коджуулан, ашиглалтын хугацаа дууссан, элэгдэлд орсон, эвдэрч ашиглах боломжгүй болсон 21 нэр төрлийн 34 ширхэг 4,254,930.0 төгрөгийн тавилга, эд хогшил, 26 нэр төрлийн 30 ширхэг 367,202,584.0 төгрөгийн машин, тоног төхөөрөмж, 1 нэр төрлийн 1 программ хангамж, 6 нэр төрлийн 32 ширхэг 3,965,000.0 төгрөгийн авто тээврийн хэрэгсэлийн хөрөнгүүдийг актлуулах санал хүргүүлээд байна.

Байгууллагын албан ажлын хэрэгцээнд 2018 оны 12 сарын 18-ны өдрийн байдлаар 2032 ширхэг 6,022,802.0 төгрөгийн бичиг хэргийн материал, 40465 ширхэг 52,529,342.0 төгрөгийн аж ахуйн материал, 337 ширхэг 70,597,183.0 төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 4,885,000.0 төгрөгийн шатахуун талон, 21 ширхэг 441,000 төгрөгийн бусад хангамжийн материалыг олгож, холбогдох тооцоог тухай бүр хийж ажилласан байна.

ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

- Газрын стратеги төлөвлөгөөг боловсруулан, батлуулах.
- Дотоод хяналт шалгалтын жилийн төлөвлөгөө гарган батлуулах, байгууллагын дотоод хяналт шалгалтыг сайжруулах.
- Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй арга хэмжээнд тавих захиалагчийн хяналтыг сайжруулах.
- Эко жолоодлогыг нэвтрүүлэх арга хэмжээг ЖАЙКА олон улсын хамтын ажиллагааны байгууллагын зүгээс хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний хяналтын чадавхийг бэхжүүлэх” төслийн хэрэгжүүлэх арга хэмжээтэй уялдуулан төлөвлөх.

-
- Агаар дахь бохирдуулагч бодисуудын агууламж, тэдгээрийн нөлөөллийг түвшинг 2019 оны 1-р улиралд багтаан гаргах.
 - Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хугацаа 14 хоног 1 цаг 43 минут байгааг багасгаж нийслэлээс тавьж байгаа нэг оронтой тоонд хүргэх гэсэн зорилтод хүрэх.
 - Одоогийн хэрэгжүүлж байгаа хэмжилтийн чиглэлүүдэд тулгуурлан эх үүсвэрүүд рүү чиглэсэн агаарын чанарт үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний саналыг боловсруулж, удирдах дээд шатны байгууллагуудад хүргүүлж, холбогдох байгууллага иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоог хангах ажлыг эрчимжүүлэх.
 - Шаталтаас ялгарах хорт хийг тодорхойлох хэмжилтийн багийг нэмэгдүүлэх.

ТАНИЛЦСАН: НАББГ-ын ДАРГА

Б.ЦАЦРАЛ

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН: ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГЫН

АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН

ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.АМАРМАА